



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ ҮНЭЛГЭЭНИЙ

ТАЙЛАН

2023



НЭГ. АГУУЛГА

- Өмнөх үг
- Мэндчилгээ
- Хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээний аргачлал

ХОЁР.

Судалгааны үр дүн

- Хүүхдээс авсан судалгааны дүн
- Насанд хүрэгчдээс авсан судалгааны үр дүн

ГУРАВ.

Үнэлгээний харьцуулалтын дүн

- Хүүхдээс авсан судалгааны харьцуулалт
- Насанд хүрэгчдээс авсан судалгааны харьцуулалт

ДӨРӨВ.

- Зөвлөмжийн хэрэгжилт

Тав.

- Зөвлөмж
- Дүгнэлт



НЭГ. ӨМНӨХ ҮГ

Хүүхдэд ээлтэй орон нутаг санаачлага нь дэлхий дахинд өсөн нэмэгдэж буй хотжилт болон төвлөрөлийг сааруулах үйл явцад хүүхдийн эрхийг бүрэн хангахад тулгамдаж буй бэрхшээл, асуудлыг илрүүлж, шийдвэрлэх зорилготой 1996 оноос эхэлсэн. Энэ санаачилга нь орон нутгийн удирдлагууд засаглалын хүрээнд хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэр гаргах үйл явцдаа хүүхэд залуучуудын эрх болон хэрэгцээнд суурилж, тэдний оролцоог нэн тэргүүнд авч үздэг. Сүүлийн жилүүдэд энэхүү санаачилгыг хэрэгжүүлж буй хот, орон нутгийн тоо өсөн нэмэгдэж байгаа юм. Монгол улс Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц, түүний нэмэлт протоколуудад нэгдэн орж олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хариуцлага хүлээн хэрэгжүүлж эхэлснээр хүүхдийн эрхийг дээдлэгч орон болохоо зарласан нь монгол хүүхдүүд тэр дундаа орон нутгийн хүүхэд өсвөр үеийнхний эрх, хамгаалалд онцгой өөрчлөлтүүдийг авчирч чадсан гэж үздэг. Тухайн улс орон олон улсын энэ баримт бичгийг хүлээн зөвшөөрч нэгдсэнээр түүний зарчим, заалтуудыг мөрдлөг болгож, үндэсний хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаагаа Конвенцид нийцүүлж, түүний хэм хэмжээг хүүхэд бүрийн амьдралд бодитоор хэрэгжүүлж, хүүхдийн эрхийг зөрчсөн эсвэл эрхээ эдлэхэд нь саад болох аливаа үйлдэл гаргахгүй байх үүрэг хүлээдэг бөгөөд хүүхэд эрүүл, аюулгүй хамгаалагдсан орчин нөхцөлд эцэг эхийн хайр халамжид өсөж хүмүүжих эрхтэйг заан тунхагласан юм.

Баримт бичгийн үзэл санааг орон нутгийнхаа хэмжээнд хэрэгжүүлж, хүүхдийн эрхийг дээдлэгч, “Хүүхдэд ээлтэй орон нутаг” болохоор зорьж байгаа Өмнөговь аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөөх Зөвлөлийн тэргүүн, аймгийн Хүүхдийн төлөө Зөвлөлийн гишүүд, Засаг даргын Тамгын газар, бүх шатны төрийн байгууллага, хамт олон, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, эцэг эх, асран хамгаалагч та бүхэнд талархал илэрхийлж байна.

“Хайрын шүхэр” НҮТББайгууллага 2019-2020 онд 1400 гаруй хүүхэд, 300 гаруй насанд хүрэгчдийг хамруулан Өмнөговь аймгийн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” анхны үнэлгээг хийсэн.

Аймаг, орон нутгийн Хүүхдэд ээлтэй байдлын үнэлгээг нэг удаа хийснээр “Хүүхдэд ээлтэй” гэж үзэх боломжгүй бөгөөд “Хүүхдэд ээлтэй байдал” нь тасралтгүй үргэлжилж, байнгын үйл явц байх ёстой гэсэн ойлголтыг орон нутгийн шат шатны удирлагын түвшинд болон иргэдэд төлөвшүүлэх хэрэгтэй байдаг нь “Хүүхдэд ээлтэй аймаг” болох төсөл хэрэгжсэн аймгуудын туршлага харуулдаг.

Өмнөговь аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлөөс “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн хүрээнд “Хүүхдэд ээлтэй байдал”-ийн үнэлгээг дахин хийлгэж, хүүхдийн аж байдлыг сайжруулах талаар төлөвлөн хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрүүдийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөө ямар байгаа, туршлага, сургамж дээрээ тулгуурлан “Бид өнөөдөр хаана байна”, цаашид хэрхэн илүү сайн ажиллах, оновчтой бодлого, хөтөлбөр үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай талаар санал санаачилга гаргаж буйд талархал илэрхийлье.

“Хайрын шүхэр” НҮТББайгууллага нь Өмнөговь аймгийн “Хүүхдэд ээлтэй байдлын үнэлгээ”-г дох удаагаа 2023 оны 11 сард тус аймгийн 6 сумын 2500 гаруй хүүхэд, өсвөр үе, залуучууд, 500 гаруй насанд хүрэгчдийг хамруулан хийсэн. Үнэлгээнд оролцогчдоос;



- “Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв”
- “Хүүхдэд ээлтэй орчин”
- “Хүүхдэд ээлтэй үйлчилгээ”
- “Хүүхдэд ээлтэй хөгжил хамгаалал”

гэсэн 4 үндсэн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд тус бүр 8-13 асуумжаар судалгааг авч нэгтгэлээ. Судалгааны тоон мэдээллийг чанарын мэдээлэлтэй хослуулах нь ач холбогдолтой учир судалгаанд хамрагдсан хүүхэд өсвөр үе, насанд хүрэгчдээс сонгон ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийсэн. Ингэснээр хүүхдийн эрх, тэдний амьдралд ямар өөрчлөлт гарсан, ямар үр нөлөөтэй байсан зэргээр өсвөр үе, залуучууд насанд хүрэгчдийн үзэл бодлыг сонсох, зөвлөлдөх үйл ажиллагаа нь хүмүүсийн өдөр тутмын амьдралыг илүү ойлгоход орон нутгийн удирдлагуудад үр дүнтэй юм.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцын 12 дугаар зүйлд;“Оролцогч улсууд өөрийн үзэл бодолтой байх чадвар бүхий хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгнө”... гэж заасан учраас энэхүү эрх нь гэр бүл, сургууль, оршин сууж буй газарт, хаана ч, аль ч түвшинд хэрэгжиж байх ёстой. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хүүхдэд нөлөөлөх бүхий л асуудлаар хүүхдийн санал бодлыг сонсох, тэрхүү санал бодолд зохих ач холбогдол өгч үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх нь насанд хүрэгчдийн үүрэг, хариуцлага юм.

Хүүхдийн өмнө үүрэг хүлээж байгаа насанд хүрэгчид бид хүүхдийн сайн сайхан байдалд гарсан ахиц дэвшлийг тодорхой хугацаанд хянаж, үнэлж байх нь “Хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээний 2 дугаар шатны ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Өмнөговь аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн Р.Сэддорж, Засаг даргын Тамгын газар, ЗДТГазрын Нийгмийн бодлогын хэлтэс, дарга Ц.Бадамцэрэн, ахлах мэргэжилтэн Ц.Мөнхсайхан, аймгийн ГБХЗХГазрын удирдлага, хамт олон, зорилтот 6 сумын ИТХурал, Засаг дарга, ЗДТГазрын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтнууд судалгаанд оролцсон бүх хүүхэд, өсвөр үе, залуучууд иргэд, насанд хүрэгчидэд талархал илэрхийлье.

“Хайрын шүхэр” НҮТББ захирал
Доржпүрэвийн Чулуунцэцэг



АРГАЧЛАЛ

Хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээний аргачлал нь хүүхдийн амьдарч буй орон нутгийг (ямар аймаг, сум, дүүрэгт амьдарч байгаагаас үл хамааран) тэдэнд ээлтэй байгаа эсэх талаар үнэлгээ хийх арга зүйг үе шаттайгаар тодорхойлсон болно. Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу цуглуулсан мэдээллийг хүүхдийн эрхийг хамгаалах олон талын зорилгоор ашиглах боломжтой. Цаашлаад үнэлгээний үр дүнг тухайн орон нутгийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөндөө тусгах, орон нутгийн хүүхдэд ээлтэй байдлыг сайжруулахад ашиглана .

Үнэлгээний аргачлал нь хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулан асуумжийн аргаар статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх байдлаар боловсруулагдсан. Ялангуяа үнэлгээний аргачлал нь тухайн орон нутгийн иргэдийн идэвхтэй оролцоонд тулгуурлах зарчимд суурилсан бөгөөд энэ нь тухайн орон нутгийн хүүхдүүд, иргэд болон бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад хүүхдийн эрхийн талаар чухал шаардлагатай мэдээллийг оновчтой хэлбэрээр хүргэх боломжийг бүрдүүлж өгнө.

Энэ аргачлалын хүрээнд хүүхдэд ээлтэй орон нутаг тооцох шалгуур үзүүлэлт нь дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байна. Үүнд:

- Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв
- Хүүхдэд ээлтэй орчин,
- Хүүхдэд ээлтэй үйлчилгээ,
- Хүүхдэд ээлтэй хөгжил хамгаалал зэрэг хамаарна.

Дээрх дөрвөн үндсэн бүрэлдэхүүн нь хүүхдэд ээлтэй орон нутгийг тодорхойлох бөгөөд бүрдэл хэсэг тус бүрт түүнийг үнэлэх асуумж, тоон үзүүлэлт, үнэлгээнүүдийг холбогдох баримт бичиг (хууль, эрх зүйн акт, тогтоол, шийдвэр, бодлого хөтөлбөр гэх мэт)-ийн судалгаан дээр үндэслэн гаргасан болно. Шалгуур үзүүлэлтүүд нь хүүхдийн эрхийн хандлагад суурилсан бөгөөд Монгол Улсын, Олон Улсын гэрээ Хүүхдийн Эрхийн тухай Конвенц (1989 он), Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хууль (2016 он)-ийг тус тус мөрдлөг болгож холбогдох зүйл заалтын хүрээнд томъёологдсон. Ийнхүү тодорхойлсон шалгуур үзүүлэлт тус бүрийнхээ хүрээнд түүнд хамаарах үнэлгээний асуултуудыг боловсруулсан бөгөөд тухайн асуултууд нь хамаарах шалгуур үзүүлэлт тус бүрийг бүрэн төлөөлнө.

Эдгээр дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дээр дурьдсан баримт бичгүүд, ялангуяа Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийн болон Хүүхэд хамгааллын тухай хуульд тулгуурлан нийт насанд хүрэгчдээс болон 13-17 насны хүүхдүүдээс “Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв”, “Хүүхдэд ээлтэй үйлчилгээ”, “Хүүхдэд ээлтэй орчин”, “Хөгжил хамгаалал” 4 бүлэг асуумжаар судалгааг авч үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж бичлээ.

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ



Хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээний аргачлал нь хүүхдийн амьдарч буй орон нутгийг (ямар аймаг, сум, дүүрэгт амьдарч байгаагаас үл хамааран) тэдэнд ээлтэй байгаа эсэх талаар үнэлгээ хийх арга зүйг үе шаттайгаар тодорхойлсон болно. Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу цуглуулсан мэдээллийг хүүхдийн эрхийг хамгаалах олон талын зорилгоор ашиглах боломжтой. Тухайлбал, үнэлгээний хүрээнд тухайн орон нутагт оршин суудаг иргэд, хүүхдүүдээс цуглуулсан мэдээлэлд үндэслэн хүүхдийн амьдарч буй орчны үнэлгээг тодорхойлж болно. Цаашлаад үнэлгээний үр дүнг тухайн орон нутгийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөндөө тусгах, орон нутгийн хүүхдэд ээлтэй байдлыг сайжруулахад ашиглана .

Үнэлгээний аргачлал нь хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулан асуумжийн аргаар статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх байдлаар боловсруулагдсан. Ялангуяа үнэлгээний аргачлал нь тухайн орон нутгийн иргэдийн идэвхтэй оролцоонд тулгуурлах зарчимд суурилсан бөгөөд энэ нь тухайн орон нутгийн хүүхдүүд, иргэд болон бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад хүүхдийн эрхийн талаар чухал шаардлагатай мэдээллийг оновчтой хэлбэрээр хүргэх боломжийг бүрдүүлж өгнө. Түүнчлэн хүүхэдтэй холбогдож үйл ажиллагаа явуулдаг иргэн, ямар ч төрлийн байгууллагууд (сургууль, цэцэрлэг, ТББ, төрийн захиргааны байгууллага, хувийн хэвшил гэх мэт) уг аргачлалыг ашиглан хүүхдийн эрхийг хангаж буй эсэх талаар өөрсдийн үнэлгээг хийх боломжтой юм.

Энэ аргачлалын хүрээнд хүүхдэд ээлтэй орон нутаг тооцох шалгуур үзүүлэлт нь дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байна. Үүнд:

- Хүүхдэд ээлтэй засаглал,төсөв
- Хүүхдэд ээлтэй орчин,
- Хүүхдэд ээлтэй үйлчилгээ,
- Хүүхдэд ээлтэй хөгжил хамгаалал зэрэг хамаарна.

Дээрх дөрвөн үндсэн бүрэлдэхүүн нь хүүхдэд ээлтэй орон нутгийг тодорхойлох бөгөөд бүрдэл хэсэг тус бүрт түүнийг үнэлэх асуумж, тоон үзүүлэлт, үнэлгээнүүдийг холбогдох баримт бичиг (хууль, эрх зүйн акт, тогтоол, шийдвэр, бодлого хөтөлбөр гэх мэт)-ийн судалгаан дээр үндэслэн гаргасан болно. Шалгуур үзүүлэлтүүд нь хүүхдийн эрхийн хандлагад суурилсан бөгөөд Монгол Улсын, Олон Улсын гэрээ Хүүхдийн Эрхийн тухай Конвенц (1989 он), Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хууль (2016 он) Монгол улсын засгийн газрын 2017 оны 9-р сарын 20-ны өдрийн 270-р тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг тус тус мөрдлөг болгож холбогдох зүйл заалтын хүрээнд томъёологдсон. Ийнхүү тодорхойлсон шалгуур үзүүлэлт тус бүрийнхээ хүрээнд түүнд хамаарах үнэлгээний асуултуудыг боловсруулсан бөгөөд тухайн асуултууд нь хамаарах шалгуур үзүүлэлт тус бүрийг бүрэн төлөөлнө.

Эдгээр дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дээр дурьдсан баримт бичгүүд, ялангуяа Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийн болон Хүүхэд хамгааллын тухай хуульд тулгуурлан нийт насанд хүрэгчдээс болон 13-17 насны хүүхдүүдээс “Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв”, “Хүүхдэд ээлтэй үйлчилгээ”, “Хүүхдэд ээлтэй орчин”, “Хөгжил хамгаалал” 4 бүлэг асуумжаар судалгааг авч үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж бичлээ.

ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО



Орон нутаг дахь хүүхдэд зориулсан засаглал төсөв, орчин, үйлчилгээ, хөгжил хамгаалал зэрэг асуудлуудын талаарх хүүхдүүдийн ойлголт, хандлага, үзэл бодлыг

- Орон нутгийн төрийн байгууллагуудын хүүхдэд ээлтэй үйл ажиллагаа
- Сургуулийн орчин, гэрийн гадна орчин, гэрээс сургууль хүртэлх замын орчин
- Төрийн үйлчилгээний байгууллагууд ялангуяа сургууль, эмнэлэгийн орчин дахь үйлчилгээ, харилцаа, хандлага
- Хүүхдүүдийг хөгжүүлэх зориулалттай хөгжлийн чиглэлийн дугуйлан, секц, тэдний үйл ажиллагаа бүх хүүхдэд тэгш хүртээмжтэй байдаг

зэрэг чиглэлээр тодруулахад энэхүү үнэлгээний зорилго оршино. Хүүхдийг эрүүл аюулгүй, ялгаварлан гадуурхалтгүй, тэгш хүртээмжтэй өсгөх ирээдүйгээ бэлдэхэд ээлтэй нийгмийг бий болгоход чиглэсэн ажлыг сайжруулах зорилгоор үнэлгээний үр дүнг үүрэг хүлээгчид, шийдвэр гаргагчид бусад өргөн хүрээний хүмүүстэй хуваалцах юм.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шалгуур үзүүлэлтүүд нь зорилгодоо хүрэх үйл явц дахь ахиц өөрчлөлтийг, эсвэл ахиц гараагүй байдлыг тодотгон харуулдаг тодорхой хугацаанд системтэй хийдэг хэмжүүр юм. Энэхүү хэмжүүрээр тодорхой хугацаанд тогтмол хэмжиж зорилгодоо хүрэх явцад ахиц гарч байгааг эсвэл ахиц гарахгүй байгааг илрүүлдэг. Үр дүнд хүрэх явцад гарч буй ахицыг хэмжих нь суурь нөхцөл байдлыг тодорхойлж хэмжихээс эхэлнэ. Суурь үзүүлэлтийн талаарх мэдээллийг цуглуулах нь үндсэндээ **“Бид өнөөдөр хаана байна”** гэдгийг ойлгохын тулд шалгуур үзүүлэлтүүдийн анхны хэмжилтийг хийнэ гэсэн үг юм.

Хүүхдийн эрхийн конвенцийг хүлээн зөвшөөрч нэгдэн орсон улс орнуудад зориулж хүүхдийн амьдралын нөхцөл байдлыг үнэлэх өргөн цар хүрээтэй хүүхдийн эрхийн ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг тус конвенцэд тодорхойлсон байдаг.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос 2017 онд Монгол Улсын 5-р тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 10 дахь хэсэгт Мэдээлэл цуглуулах талаар:

1. Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн ерөнхий арга хэмжээний талаар Хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж 5-ыг (2003) хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг өгсөн байдаг. Үүнд:

(a) Мэдээлэл цуглуулах тогтолцоогоо аль болохоор яаралтайгаар үр дүнтэйгээр сайжруулах. Бүх хүүхдийн нөхцөл байдал, нэн ялангуяа эмзэг байдлын, нэн хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн талаар дүгнэлт шинжилгээг сайжруулахын тулд Конвенцийн бүх хүрээг хамруулан хүүхдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, газарзүйн байршил, яс үндэс, нийгэм-эдийн засгийн байдал зэрэг задаргаагаар мэдээллийг цуглуулах;

(b) Тухайн асуудлаар ажилладаг төрийн байгууллагууд мэдээллийн өгөгдөл болон шалгуур үзүүлэлтүүдийг нэгдсэн байдлаар ашигладаг, тэдгээрийг Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх бодлого, шийдвэр, төсөл хөтөлбөрийг боловсруулах, хяналт, үнэлгээ хийхдээ ашигладаг байхад анхаарах;

(c) Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/145 тоот тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ын хүрээнд 129 үзүүлэлтийг хуулиар хүүхдийн хамгаалагдах эрхийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй салбарын байгууллагууд үндэсний хэмжээнд гаргаж байна.


Тухайн аймаг хүүхдийн эрхийн хэрэгжилт, эрх тэгш байдлын илэрхийлэл, мэдээлэл, тоо баримт цуглуулах, олж авсан тоо баримтаа бодлого, төлөвлөлтдөө ашиглах нь хамгийн



чухал байдаг. Энэ хэрэгцээ шаардлагаас улбаалан НҮБ-ийн Хүүхдийн сан хүүхдэд ээлтэй орон нутаг шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан тухайн орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан “Аймгийн хүүхдэд ээлтэй” байдлыг үнэлэхдээ хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн боловсрол, чөлөөт цагийн орчин, хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн оролцоо, хүүхдийн амьдрах орчин гэсэн үндсэн бүлгийн хүрээнд дэд асуумж үзүүлэлтийг сонгох боломжтой гэж үздэг.

СУДАЛГАА ХИЙСЭН ХУГАЦАА, ҮЙЛ ЯВЦ

Судалгааны мэдээллийг цуглуулах ажлын явц: Асуулгыг бөглүүлэхээс өмнө судалгаанд оролцогч хүүхдүүд, насанд хүрэгчдэд Хүүхдэд ээлтэй орон нутгийн хөтөлбөр, санаачилга, 2020 онд хийсэн анхны үнэлгээний талаар мэдээлэл өгч, асуумжын талаар тайлбарлаж ажилласан.



ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН


I. ХҮҮХДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1.1 ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЗАСАГЛАЛ ТӨСӨВ

Энэхүү асуулгыг хүүхдүүдэд ойлгогдох байдлыг урьдчилан тандаж уншуулж засварласны үндсэн дээр ТИЙМ, ҮГҮЙ, МЭДЭХГҮЙ гэсэн хариултаар хүүхдүүдээс асуумж авлаа.


1. Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн талаар мэдэх үү?






Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн талаар хүүхдүүдийн 53% нь тийм гэсэн хариултыг өгсөн ч, үгүй, мэдэхгүй хариулт нь 47% байна. Тиймээс хуулинд заасан, хүүхдүүдийн эрх ашгийн төлөө ажилладаг, салбар дундын оролцоог хангасан анхан шатны энэ нэгжийн талаар сайн сурталчилж, ойлголтыг өгөх нь зүйтэй юм.

2. Танай орон нутагт хүүхдэд зориулсан тусгай бодлого, хөтөлбөрүүд байдаг уу?



Аймаг орон нутгаас боловсруулан гаргаж байгаа бодлого, хөтөлбөрийн талаарх хүүхдүүд мэдлэг мэдээлэлтэй байгаа нь хариултаас харагдаж байна. Гэхдээ нийт хүүхдүүдийн 39 % нь мэдэхгүй, үгүй гэсэн нь энэ талын мэдээллийг хангалттай авч чадахгүй байгаа юм.


3. Сум/хорооноос хүүхдэд зориулсан үйл ажиллагаанд зарцуулагдах мөнгө, санхүүжилтийн талаар олон нийтэд мэдээлдэг үү?



Хүүхдэд зориулсан үйл ажиллагаанд хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, зарцуулагдаж байгаа хөрөнгө мөнгө хангалттай байдаг ч, энэ талаар хүүхэд, иргэд мэдээлэл дутмаг байгаа нь хариултаас харагдаж байна. Нийт хүүхдүүдийн 42% нь мэдээлдэг гэсэн бол 58% нь үгүй, мэдэхгүй гэж хариулсан байна. Цаашид хүүхдийн талаар хийж байгаа аливаа хөрөнгө оруулалт, хөрөнгө санхүүгийн асуудлыг ил тод мэдээлж байх нь зөв юм.




4. Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргахдаа төр, захиргааны байгууллага болон ТББ-аас хүүхэд, эцэг, эхчүүдийн дунд санал асуулга явуулдаг уу?



Хүүхдүүдийн 44% орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргахдаа төр, захиргааны байгууллага болон ТББ-аас санал асуулга явуулдаг уу? гэсэн асуултанд тийм гэж хариулсан бол 30% нь мэдэхгүй 26 % нь үгүй, зарим тохиолдолд төрийн байгууллагаас санал авдаг гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд байгууллагууд ялангуяа шийдвэр гаргагч төр захиргааны байгууллагууд хүүхдэд хандсан харилцаа дутмаг, хүүхдийн асуудлаар үйл ажиллагаа зохион байгуулах, шийдвэр гаргахдаа төрийн байгууллага хүүхдүүдийн санаа бодлыг тусгах асуудал учир дутагдалтай нь харагдаж байна.


5. Орон нутгийн захиргааны байгууллагаас болон хүүхдийн төлөө байгууллагаас олон нийтэд |багш, эмч, өмгөөлөгч, цагдаа, нийгмийн ажилтан, иргэд, төрийн албан хаагчид гэх мэт| зориулан хүүхдийн асуудлаар сургалт хэлэлцүүлэг зохион байгуулдаг уу?



Орон нутгийн захиргааны болон хүүхдийн төлөө байгууллагаас олон нийтэд зориулан хүүхдийн асуудлаар сургалт хэлэлцүүлгийг сайн зохион байгуулдаг гэж нийт хүүхдүүдийн 80 % хариулсан байгаа нь харьцангуй өндөр хувьтай байна. Тиймээс энэ талаар зохион байгуулах ажлыг цаашид улам сайжруулан ажилласанаар хүүхдийн асуудлаар иргэд, хүүхэд, залуучууд бүрэн дүүрэн мэдээлэлтэй болно гэж үзэж байна.

6. Танай орон нутгийн төрийн байгууллагууд хүүхэд, эцэг эхийн санал, хүсэлтийг хүлээн авч, хариу өгдөг хайрцаг, дэвтэр ажиллуулдаг уу? арга хэмжээ зохион байгуулдаг уу?






Хүүхэд, эцэг эхийн санал, хүсэлтийг авдаг дэвтэр хайрцаг ажиллуулдаг талаар нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 62% нь тийм гэж хариулсан байна. Уулзалтын явцад хүүхдүүд “Хүүхдээ сонсох өдөр”-ийг сар бүр зохион байгуулдаг болсон талаар сайшааж байгаа ч зарим үед хувиараараа явагдахгүй үе байдаг гэсэн юм.

Хүүхдээ сонсох өдрийн арга хэмжээнд оролцдог дарга нар эхлэхэд нь сууж байгаад, утсаар яриад л гараад явчихдаг. Яг хүүхдүүд саналаа хэлэх үед бараг том хүн байхгүй ганц Нийгмийн ажилтан л үлддэг.Ц. 15 настай


7. Гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хүүхэд, олон нийтэд эргэн мэдээлдэг үү?



Гарсан шийдвэрийн хувьд хүүхдүүдэд эргэн мэдээлдэг эсэх дээр аймгийн хувьд хүүхдүүдээс гарсан санал санаачилгыг сонсдог мөн гаргасан шийдвэрээ танилцуулдаг нь уламжлал болсон боловч тэр нь нийт хүүхдүүдэд хүрч чадахгүй байгаа бөгөөд гарсан санал санаачилга, шийдвэрүүдийн талаар нарийн мэдээлэлгүй байна.

8. Хүүхдийн төлөө байгууллага болон сум/хорооны нийгмийн ажилтнууд хүүхдүүдтэй ярилцаж, мэдээлэл солилцдог уу?






Сум, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн төлөө байгууллагынхан хүүхдүүдтэй ярилцаж мэдээлэл солилцдог гэж хүүхдүүдийн 74 хувь хариулсан байгаа нь мэргэжлийн байгууллагын ажилтнууд нь хүүхдүүдтэй ойр дотно, чин сэтгэлээсээ ажилладаг нь харагдаж байна. Хүүхдүүд ч талархалтай байдгаа ярилцлагын үед илэрхийлж байсан юм.

Манай оролцооны байгууллагыг хариуцсан эгч биднийг их сонсдог, бидэнтэй маш дотно байдаг, их зүйлийг энгийн байдлаар зааж сургадаг. Оролцооны байгууллагын сурагч. Эм 16 настай.


9. Хүүхдийн эрх ашигт нөлөөлөх асуудлын талаарх ИТХ-ын хуралдааны үйл явц олон нийтэд нээлттэй байдаг уу?/мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулдаг эсэх?/



Энэ асуумжид 53% нь тийм, 47% нь үгүй, мэдэхгүй гэж хариулсан байна. Аймгийн ИТХ-ын хуралдааны үйл явцыг олон нийтэд мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулан хүргэдэг. Харин хүүхдийн эрх ашигт нөлөөлөх асуудлын талаар ИТХурлаас шууд дамжуулан бүх хүүхдэд нээлттэй дамжуулдагуу гэдэг талаар хүүхдүүдээс тодруулан ярилцлагын үед асуухад энэ талаар ойлголт муутай байсан юм.


10. Орон нутгийн захиргааны байгууллагуудаас хүүхдэд зориулсан төсөв, хөрөнгийг нэмэгдүүлэх талаар санал, санаачлага өрнүүлдэг үү?






Орон нутгийн захиргааны байгууллагуудаас хүүхдэд зориулсан төсөв, хөрөнгийг нэмэгдүүлэх талаар санал санаачилга өрнүүлдэг үү? гэсэн асуумжид 60% нь мэдэхгүй, үгүй гэж хариулсан нь хүүхдүүдэд энэ талын мэдлэг мэдээлэл дутмаг байгаа нь харагдаж байна.

11. Орон нутгийн албан хаагчид хүүхдийн эрхийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байдаг уу?



Хүүхдүүд хариулахдаа бидэнтэй шууд харилцдаг төрийн албан хаагчид хүүхдийн эрхийн талаар мэдлэг мэдээлэлтэй байдаг гэхдээ бусад байгууллагын хүмүүс хүүхдийн эрхийн талаарх мэдлэг мэдээлэл бага юм шиг санагддаг биднийг байгууллагуудад үйлчлүүлэх гээд очиход тоохгүй байх, ялгаварлах, үйлчилгээ үзүүлэхгүй байх зэрэг асуудлууд их гардаг гэж хариулсан байна.

12. Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд орон нутгийн захиргааны байгууллагаас ямар нэгэн арга хэмжээ авдаг уу ?




Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд арга хэмжээ авдаг гэж хүүхдүүдийн 70% нь хариулсан байгаа ч, 30% нь мэдэхгүй, үгүй гэж хариулсан байна. Чиг үүргийн дагуу



мэргэжлийн байгууллага арга хэмжээ авахаас гадна бусад холбогдох байгууллагууд ч хүүхдийн эрхийн зөрчилд анхаарах ёстойг Хүүхдийн эрхийн болон Хүүхэд хамгааллын тухай хуулинд тусгаж өгсөн байдаг.

13. Хүүхдийн гаргасан санаачлагын дагуу төр, захиргааны байгууллага ямар нэгэн үйл ажиллагаа зохион байгуулдаг уу?




Хүүхдүүд өөрсдийн эрх ашигт нийцсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулахад оролцож санал санаачилга гаргадаг ч, нийт хүүхдийг хамарч чаддаггүй. Цөөн хэдэн хүүхэд л оролцдог. “Хүүхдээ сонсоё” арга хэмжээг тогтмол зохион байгуулах талаар Засаг даргын захирамж гарсан. Гарсан санал санаачилгыг шийдвэрлэх тал дээр бага зэрэг дутмаг байдаг гэж хариулж байсан.

/Хүүхдийн эрхийн тухай хуулиас 8-р зүйл 1.2. Хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох эрхтэй байдаг гэж заасан байдаг./

1.2 ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН


1. Танай орон нутагт явган хүний гарц, замын тэмдэг тэмдэглэгээ хангалттай байдаг уу?



Орон нутагт явган хүний гарц, замын тэмдэг тэмдэглэгээ хангалттай байдаг уу гэсэн асуумжид хүүхдүүдийн 55% нь дунд, муу гэж хариулсан тул, хүүхэд аюулгүй, эрсдэлгүй зорчиход гарц, замын тэмдэг тэмдэглэгээ чухал юм.


2. Танай өрх гэр, сургууль, цэцэрлэгийн ойролцоо ногоон байгууламж байдаг уу?






Ногоон байгууламжийн талаар хүүхдүүд сэтгэл ханамж өндөр буюу 80% тай сайн гэж хариулсан байна. Цаашид ч ногоон байгууламжаа нэмэгдүүлэх, тарьсан мод бутгаа арчилж ургуулахад илүү анхаарах нь зөв юм.

3. Танай гэрийн гадаа, гудамж талбай хаягжилт сайн байдаг уу?



Хүүхдүүд өөрийн оршин суугаа газрын хаягжилт ямар байдаг талаар асуухад 56% нь сайн 44 % нь дунд муу гэж хариулсан байна.


4. Танай амьдрах орчинд хүүхдийн тоглоомын талбай, тоглох тоглоом байдаг уу?



Хүүхэд тоглоомоор дамжин хөгжиж байдаг. Өөрсдийн оршин суугаа газар буюу амьдрах орчинд тоглоомын талбай, тоглоом сайн байдаг гэж нийт хүүхдүүдийн 65% нь хариулсан байна. Хэдийгээр тоглоомын талбай, тоглоом байдаг ч хүүхдийн тоглоомын талбайн стандартын шаардлагыг төдийлөн хангахгүй байдаг гэж тэд ярьсан юм.


5. Хүүхдүүд гадаа гудамжинд аюулгүй явах, тоглох боломж бүрдсэн үү? /гэрэлтүүлэг/






Хүүхэд аюулгүй орчинд амьдрах эрхтэй талаар хуулинд заасан байдаг. Аюулгүй орчны нэг болох гудамжны гэрэлтүүлэгтэй талаар нийт хүүхдүүдийн 56% нь сайн гэж хариулсан ч 44% нь дунд, муу гэж хариулсан байгаа нь орчны гэрэлтүүлэг бүрэн дүүрэн хангалттай биш байна гэдэгтэй санал нийлж байна.

6. Танай ангийн сандал, ширээ суухад тохиромжтой юу?, хүртээмжтэй юу?



Сурах үйл явцад нөлөөлдөг гол хүчин зүйл сургалтын орчин буюу ширээ сандал байдаг. Та нарын ширээ сандал, тохиромжтой, хүртээмжтэй талаар хүүхдүүд сайн гэж хариулжээ.


7. Танай сургууль/цэцэрлэгийн бие засах газар, гар угаах угаалтуур зэрэг нь хүүхдүүдэд хүрэлцээтэй, нас болон хүйсний онцлогт тохирсон байдаг уу?



Сургууль бүрт эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартад нийцсэн ариун цэврийн байгууламж бие засах газар, гар угаалтуур байх ёстой. Харин энэ талаар хүүдүүд маш сэтгэл дундуур байгаа нь хариултаас харагдсан ба 32% нь сайн, 68% нь дунд муу гэсэн байна. Бие засах газар байдаг ч, тэдний насны онцлогт тохирохгүй шаардлага хангадаггүй гэж ярилцлагад хариулж байсан юм.

8. Эмнэлэгт хүүхдэд зориулсан тусгай үзлэгийн өрөө байдаг уу?






Эрүүл мэндийн Сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу Өмнөговь аймгийн бүсийн оношлогооны төв нь хүүхдийн үзлэгийн өрөө болон өсвөр үеийн кабинетын үйл ажиллагаа явагддаг боловч хүүхэд өсвөр үеийнхэнд зориулсан кабинетийн талаар хүүхдүүд өөрсдөө мэдээлэл багатай, эцэг эх, асран хамгаалагчид мэдээлэл хүргэх шаардлагатай байна.


1.3 ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Хүүхдийн вакциныг товлосон хугацаанд нь хийдэг үү?



Хүүхдийн товлोलт вакциныг төрсөн цагаас нь эхэлж хуваарийн дагуу хийлгэж хэвшсэн байдаг тул хүүхдүүд энэ талын мэдлэг мэдээлэл сайтай байдаг учраас өндөр хувьтай хариулсан байна.


2. Та нарт урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийдэг үү?



Урьдчилан сэргийлэх үзлэгийн талаар нийт хүүхдийн 58 % нь сайн гэж хариулсан ч, 42% нь дунд муу гэж хариулсан байгаа нь анхаарах асуудал юм. Урьдчилан сэргийлэх үзлэгт сайн хамрагдсанаар сэргийлж болох өвчлөл, осол гэмтлээс өөрийгөө хамгаалах ач холбогдолтой гэдгийг ойлгуулж таниулах шаардлагатай.




3. Хүүхдийн шүдний өвчлөлийг оношлох, эмчлэх, зөвлөгөө өгөх газар байдаг уу?




Хүүхдийн өвчлөлд хамгийн их зонхилдог өвчлөл бол хүүхдийн шүдний өвчлөл юм. Шүдний өвчтэй хүүхдүүдийн 80 гаруй хувь нь буруу угаалтаас болдог гэсэн үндэсний хэмжээний судалгаа байдаг. Тиймээс хүүхдийн шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгөх, өвчнийг оношлох, эмчлэх газар дунд муу гэж 60% нь хариулсан байгаа юм. Шүдний өвчин нь бусад өвчний суурь болдог учраас шүдээ хэрхэн хамгаалах талаар хүүхдүүдэд багаас нь мэдлэг өгөх нь зүйтэй байна.

4. Танай сургуульд мэргэжлийн багш хангалттай байдаг уу?



Хүүхдүүд сургуульд мэргэжлийн багш нар хангалттай сайн байдаг ч, сумдад өөр хичээлийн багш нар орох тохиолдол их байдаг хэмээн хариулсан байна.


5. Танай сургуулийн цахилгаан, дулаан сайн байдаг уу?



Сургууль нь хүүхдэд ээлтэй орчин байх ёстой. Ялангуяа дулаахан орчинд хүүхдүүд тав тухтай хичээллэх нөхцөл бүрддэг. Тиймээс хүүхдүүд сургуулийнхаа цахилгаан дулааны талаар 62% нь сайн гэж хариулсан ч 38% нь дунд муу гэж хариулсан байна.


6. Сургууль, цэцэрлэгт хүүхдүүдэд зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан үдийн цай хоол өгдөг үү?






Хүүхдийн суурь хэрэгцээг хангадаг үйлчилгээний нэг үдийн цай хоол юм. Энэ талаар хүүхдүүдийн 78% нь сайн гэж хариулсан байна. Орон нутгийн зүгээс үдийн цай хоолны асуудалд анхаарч 6-р ангийн хүүхдүүдэд цай хоол өгч эхэлсэн нь хүүхдийн эрүүл мэндэд оруулж байгаа хөрөнгө оруулалт юм гэж үзэж байна.

7. Сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэгш хамрагдах боломж байдаг уу?




Хүүхэд бүр сурч боловсрох эрхтэй байдаг. Тусгай хэрэгцээт буюу ХБХүүхэд сургууль цэцэрлэгт тэгш хамрагдах боломж байдаг эсэх талаар хүүхдүүдээс асуухад 69% нь дунд муу гэж хариулсан нь анхаарал татаж байгаа юм. ХБХ-дийн сурч боловсрох талаар хууль эрх зүйн актууд хангалттай байгаа ч, орчин, үйлчилгээний хувьд хангалтгүй байгаа нь харагдаж байна. Энэ асуудал нь зөвхөн Өмнөговь аймгийн хувьд ч биш, бусад газруудад адил тулгамдаад байгаа асуудал юм.

8. Сургууль цэцэрлэгийн бие засах газар тогтмол нээлттэй, цэвэрхэн байдаг уу?




Сургууль цэцэрлэгийн бие засах газар тогтмол нээлттэй цэвэрхэн байдаг талаар хүүхдүүдийн 58% нь сайн гэж хариулсан ч, 42% нь дунд муу гэж хариулсан байгаа нь анхаарах асуудал байна. Ариун цэврийн байгууламж нь тогтмол цэвэрхэн, байнга нээлттэй байх нь хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн нэг хэсэг гэж үзэх ёстой.

9. Танай орон нутагт хүүхдийн мэргэжлийн эмч хангалттай байдаг уу? .



Хүүхдийн мэргэжлийн эмчийн хүрэлцээ хангамж ямар байдаг талаар хүүхдүүд сайн гэж 65% нь хариулсан байна.

Төрийн үйлчилгээний байгууллагууд та нарт хэр ээлтэй үйлчилдэг гэж үзэж байна вэ?




Энэхүү асуултанд хүүхдүүд аж ахуй нэгж, эрүүл мэндийн байгууллага, боловсролын байгууллагууд, цагдаа, аюулгүй байдал хариуцсан байгууллага, орон нутгийн засаг захиргааг өөрсдийн бодлоор хэрхэн хүүхдэд ээлтэй ажилладгийг үнэллээ.

Хамгийн их хүүхдэд ээлгүй, буруу зан байдалтай газраар: Хүүхэд томчуудтай шууд байдлаар харьцдаг засаг захиргаа, нутгийн удирдлагыг нийт судалгаанд оролцогчдын 15,1% маш муу хэмээн үнэлсэн бол цагдаа, аюулгүй байдал хариуцсан байгууллагуудыг 33% сайн гэж үнэлсэн байна.

ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ


1. Танай орон нутагт хүүхэд хөгжлийн танхим байдаг уу?





Хүүхдэд ээлтэй хөгжил хамгааллын бүлэг үзүүлэлтэнд 11 асуумжаар асуулга авсан юм. Хүүхэд хөгжлийн танхим хангалттай буюу сургууль бүрт, оролцооны байгууллагуудын хүүхдүүд цугладаг өрөө танхим байдаг уу гэсэн асуумжид 72% нь сайн байдаг гэж хариулсан нь хүүхдүүд эвлэлдэн нэгдэх, өөрийгөө болоод үе тэнгийн найзуудтайгаа үзэл бодлоо хувалцах цуглах үедээ өрөө танхимтай байдаг нь харагдаж байна.

2. Чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн парк байдаг уу?




Хүүхдийн чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн парк байдаг уу гэсэн асуумжид 76% нь сайн байдаг гэж хариулсан байна. Аймгийн төвд байдаг хүүхдийн парк, цэцэрлэгт хүрээлэн нь хүүхэд залуучуудын сэтгэлд хүрсэн бүтээн байгуулалт болсон байгаа юм. Зарим сумдад парк, цэцэрлэгт хүрээлэн хангалтгүй байхгүй гэхэд болно доо гэж ярилцлага өгч байсан юм.

Аймагт байдаг парк-д нэг зун очиж тоглосон. Байнга очоод байж чаддаггүй. Сум болгонд байвал гоё л байна. 15 настай С


3. Танай сургууль дээр чамд чөлөөт цагаа өнгөрөөх газар /биеийн тамирын заал, дугуйлан, секц гэх мэт/ байдаг уу?






Сургууль дээр хүүхдүүд чөлөөт цагаа өнгөрөөх биеийн тамирын заал, дугуйлан секц байдаг уу гэхэд хүүхдүүдийн 54% нь сайн байдаг гэж хариулсан бол 46% нь дунд муу гэж хариулсан байна. Зарим үед заал авах нь хүүхэд бүрт олддоггүй. Нөгөө л тоглодог хэдэн хүүхдүүд нь байнга зааланд тоглодог. Сургууль дээр бол бүр олддоггүй. Секц дугуйлан байдаг. Гэхдээ хүүхэд бүр хамрагдах боломжгүй юм шиг санагддаг. Энэ тал дээр анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

4. Хүүхдэд зориулсан үзвэр үйлчилгээ хангалттай байдаг уу?



Хүүхдэд зориулсан үзвэр үйлчилгээний хувьд 55% нь хангалттай сайн гэж хариулсан боловч 45% нь дунд муу гэж хариулсан байгаа нь хүүхдийн онцлогт тохирсон үзвэр үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай байна гэдгийг илтгэж байна.

5. Хүүхдэд зориулсан соёл,урлаг,спортын арга хэмжээ зохион байгуулж, хүүхдүүдийг идэвхтэй оролцуулдаг уу?




Соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулж, та нар идэвхтэй оролцдог уу гэж асуухад нийт хүүхдийн 69% нь сайн гэж хариулсан нь энэ чиглэлийн арга хэмжээг




сургуулиас гадна ГБХЗХГазар, БТСГазар, Хүүхдийн ордон зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагууд зохион байгуулдаг талаар хүүхдүүд сэтгэл өндөр байсан юм.

6. Та нарын хичээл хуваарийн дагуу бүрэн явагддаг уу?




Энэ бүлгийн хамгийн өндөр хувьтай, та нарын хичээл хуваарийн дагуу бүрэн явагддагуу гэсэн асуумжид 90% нь сайн тийм гэж хариулсан байна.

7. Хүүхдийн өөрийн удирдлагын болон оролцооны байгууллагуудын талаар мэдэх үү?



Хүүхдүүдийн нийгмийн амьдралд оролцох үндсэн эрхийн нэг үзүүлэлт болох хүүхдийн өөрийн удирдлагын болон оролцооны байгууллагуудын талаар 72% нь тийм гэж хариулсан байна. Харин 10% нь мэдэхгүй, 18% нь үгүй гэсэн байгаа нь цаашид хүүхэд бүрт энэ талын ойлголтыг өгөх нь чухал байгаа юм.


8. Танай орон нутагт хүүхэд хамгааллын хамтарсан баг байдаг уу?



Хүүхэд хамгааллын анхан шатны нэгж болох Хамтарсан багийн талаар хүүхдүүдийн 78% нь тийм гэж хариулсан байна. Харин 22% нь үгүй мэдэхгүй гэсэн байна.




9. Сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа гадуурхалт, дээрэлхэх, доромжлох асуудлын талаар сургуулийн багш, нийгмийн ажилтан, сургуулийн захирал арга хэмжээ авдаг уу?



Сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа гадуурхалт, дээрэлхэх, доромжлох асуудлын талаар сургуулийн захирал, багш, НАжилтан арга хэмжээ авдаг уу гэсэн асуумжид 31% нь тийм, 48% нь үгүй, 21% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Энэ талаар анги удирдсан багш, НАжилтан, Сэтгэл зүйч, удирдлагууд хамтарч тодорхой ажлыг зохион байгуулж ажиллах зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

Доромжлох дээрэлхэх бүүр дасал болсон зүйл. Хүүхдүүд дунд үе тэнгийн дарамт их байдаг. Ялангуяа нэгэндээ хоч өгөх, үг хэлээр доромжлох тохиолдол их байдаг. Ангийн багшдаа хэлэхэд нэг удаадаа арга хэмжээ аваад л өнгөрнө. Зарим багш нар бүр тоодог ч үгүй. Багш менежерт хэлэхээр нэмэр байхгүй учраас бид чимээгүй л өнгөрдөг. Аливаа асуудлыг хэрхэн шийдэхээ мэдэхгүй, үе тэнгийхэндээ дарамтлуулаад яваад байх нь бидний зан чанар сэтгэл санаанд муугаар нөлөөлдөг. /Хүүхдүүдтэй хийсэн ярилцлагаас/

10. Орон нутгийн байгууллагуудаас өнчин, асран хамгаалагчгүй, нэн ядуу өрхийн хүүхэд, хурдан морь унадаг, хөдөлмөр эрхэлдэг гэх мэт хүүхдүүдэд анхаарал хандуулдаг уу?




Орон нутгийн байгууллагуудаас өнчин, асран хамгаалагчгүй, нэн ядуу өрхийн хүүхэд, хөдөлмөр эрхэлдэг, хурдан морь унадаг хүүхдүүдэд анхаарал хандуулдаг уу гэсэн асуумжид 51% нь тийм, 37% нь үгүй, 12% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Орон нутгийн зайлшгүй анхаарч ажиллах бүлэг бол дээрх хүүхдүүд юм. Тиймээс цаашид холбогдох байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай юм.



Өнчин, асран хамгаалагчгүй, хурдан морь унадаг зэрэг хүүхдүүдэд анхаарал хандуулдаггүй ямар нэгэн арга хэмжээ авдаггүй юм шиг надад санагддаг. 14 настай,

11. Орон нутгийн байгууллагуудаас гэмт хэрэгт холбогдсон, халдлагад өртсөн, эсвэл гэр бүлийн хүчирхийллийн гэрч болсон гэх мэт хүүхдүүдэд зөвлөгөө тусламж үзүүлдэг үү?



Гэмт хэрэгт холбогдсон, гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогч хүүхдүүдэд зөвлөгөө тусламж үзүүлдэг үү гэсэн асуумжид 76% нь тийм гэж хариулсан байна. Хүүхэд хамгааллын тухай хуулинд зааснаар хариу үйлчилгээг мэргэжлийн байгууллага, баг шуурхай хүргэн ажиллах ёстой байдаг.



II. НАСАНД ХҮРЭГЧДЭЭС АВСАН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЗАСАГЛАЛ, ТӨСӨВ


Энэхүү асуулгыг насанд хүрэгчдээс авсан бөгөөд 1-10 хүртэлх үнэлгээгээр үнэлүүлэн судалгаа авлаа.

Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв

Хүснэгт 1

№	Асуултууд	Үнэлгээ									
		1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн талаар мэдэх үү?										
2	Танай орон нутагт хүүхдэд зориулсан тусгай бодлого, хөтөлбөрүүд байдаг уу?										
3	Сум/хорооноос хүүхдэд зориулсан үйл ажиллагаанд зарцуулах мөнгөний талаар олон нийтэд мэдээлдэг үү?										
4	Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргахдаа төр, захиргааны байгууллага болон ТББ-аас хүүхэд, эцэг, эхчүүдийн дунд санал асуулга явуулдаг уу?										
5	Орон нутгийн захиргааны байгууллагаас болон хүүхдийн төлөө байгууллагаас олон нийтэд (багш, эмч, өмгөөлөгч, цагдаа, нийгмийн ажилтан, иргэд, төрийн албан хаагчид гэх мэт) зориулан хүүхдийн асуудлаар сургалт хэлэлцүүлэг зохион байгуулдаг уу?										
6	Танай орон нутгийн төрийн байгууллагууд хүүхэд, эцэг эхийн санал, хүсэлтийг хүлээн авч, хариу өгдөг хайрцаг, дэвтэр ажиллуулдаг уу? арга хэмжээ зохион байгуулдаг уу?										
7	Гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хүүхэд, олон нийтэд эргэн мэдээлдэг үү?										
8	Хүүхдийн төлөө байгууллага болон сум/хорооны нийгмийн ажилтнууд хүүхдүүдтэй ярилцаж, мэдээлэл солилцдог уу?										
9	Хүүхдийн эрх ашигт нөлөөлөх асуудлын талаарх ИТХ-ын хуралдааны үйл явц олон нийтэд нээлттэй байдаг уу?/мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулдаг эсэх?										
10	Орон нутгийн захиргааны байгууллагуудаас хүүхдэд зориулсан төсөв, хөрөнгийг нэмэгдүүлэх талаар санал, санаачлага өрнүүлдэг үү?										
11	Орон нутгийн албан хаагчид хүүхдийн эрхийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байдаг уу?										
12	Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд орон нутгийн захиргааны байгууллагаас ямар нэгэн арга хэмжээ авдаг уу?										
13	Хүүхдийн гаргасан санаачлагын дагуу төр, захиргааны байгууллага ямар нэгэн үйл ажиллагаа зохион байгуулдаг уу?										





Хүүхдэд ээлтэй засаглал 1-р зорилтын хүрээнд эцэг эхчүүд дүгнэхдээ “Сум/хорооноос хүүхдэд зориулсан үйл ажиллагаанд зарцуулах мөнгөний талаар олон нийтэд мэдээлдэг үү?” гэсэн асуумжинд хамгийн доогуур буюу 5.1 оноо, “Хүүхдийн төлөө байгууллага, сум хорооны нийгмийн ажилтнууд хүүхдүүдтэй ярилцаж, мэдээлэл солилцдог уу?”, Орон нутгийн албан хаагчид хүүхдийн эрхийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байдаг уу? гэсэн асуумжинд дээгүүр буюу 9,1-9,6 онооны хариултыг өгсөн байна.

Монгол улсын хүүхдийн эрхийн тухай хууль /2016 он/-ийн 16-р зүйлд: Хүүхдийн Төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, 17-р зүйлд: Бүх шатны Засаг даргын үүрэг, оролцоог хуульчилж өгсөн. Аймаг сум бүрт засаг даргаар ахлуулсан хүүхдийн зөвлөл ажилладаг. Зөвлөлийн бүрэлдэхүүнд хүүхдийн оролцох эрхийг дээдэлж хүүхдийн оролцоог хангах талаар /хуулинд тусгаагүй ч/ төрийн захиргааны төв байгууллагаас чиглэл үүрэг өгөгдсөн байдаг. Орон нутгийн хүүхдийн төлөө зөвлөлүүд нь хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого шийдвэр хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авах, энэ талаар гарсан санал санаачлагыг дэмжих, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах үүрэгтэй. Хүүхэдтэй холбоотой аймгийн бодлого хөтөлбөр дэд хөтөлбөр, журам болзлуудыг батлахдаа хүүхдүүдээс өөрсдөөс нь санал авах ялангуяа урьдчилсан хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулж тэднээр дүгнэлт гаргуулан батлах нь хэрэгжилтэнд илүү үр дүнтэй байх болно.

Хүүхдийн өөрийн удирдлагын буюу оролцооны байгууллагуудын зохион байгуулдаг уламжлалт ажлын нэг аймгийн хүүхдийн чуулган жил бүр зохион байгуулагддаг. Энэ чуулганаар хүүхдүүд шийдвэр гаргах түвшнийхэнд болон томчуудад дуу хоолойгоо хүргэдэг чухал арга хэмжээ байдаг тул энэ үеэр хүүхдүүдэд шаардлагатай мэдээллүүдийг хүргэх тэдний санал хүсэлт сонсох зэрэг ажилуудыг зохион байгуулж болдог. Нөгөөтэйгүүр орон нутаг бүр “Хүүхдээ сонсох өдөр”-ийг шийдвэр гаргаж эсвэл тусгай хувиараар баталгаажуулан зохион байгуулдаг. Хүүхдээ сонсох өдрийг зохион байгуулах ач холбогдол нь хүүхэд бүрт хүрч ажиллах нэгэн боломж олгодог онцлогтой ажил юм.

1.4 ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН



№	Асуултууд	Үнэлгээ									
		1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Танай орон нутагт явган хүний гарц, замын тэмдэг тэмдэглэгээ хангалттай байдаг уу?										
2	Танай өрх гэр, сургууль, цэцэрлэгийн ойролцоо ногоон байгууламж байдаг уу?										
3	Танай гэрийн гадаа, гудамж талбай хаягжилт сайн байдаг уу?										
4	Танай амьдрах орчинд хүүхдийн тоглоомын талбай, тоглох тоглоом байдаг уу?										
5	Хүүхдүүд гадаа гудамжинд аюулгүй явах, тоглох боломж бүрдсэн үү? /гэрэлтүүлэг/										
6	Танай хүүхдийн ангийн сандал, ширээ суухад тохиромжтой юу? хүртээмжтэй юу?										
7	Танай хүүхдийн сургууль\цэцэрлэгийн бие засах газар, гар угаах угаалтуур зэрэг нь хүүхдүүдэд хүрэлцээтэй, нас болон хүйсний онцлогт тохирсон байдаг уу?										
8	Эмнэлэгт хүүхдэд зориулсан тусгай үзлэгийн өрөө байдаг уу?										




Хүүхдэд ээлтэй орчин зорилтын хүрээнд хүүхдүүд “Танай орон нутагт явган хүний гарц, замын тэмдэг тэмдэглэгээ хангалттай байдаг уу?”, “Танай амьдрах орчинд хүүхдийн тоглоомын талбай, тоглох тоглоом байдаг уу?”, “Танай сургууль\цэцэрлэгийн бие засах газар, гар угаах угаалтуур зэрэг нь хүүхдүүдэд хүрэлцээтэй, нас болон хүйсний онцлогт тохирсон байдаг уу?” гэсэн асуумжинд бага оноо буюу 3,7-4.5 онооны хариултыг өгсөн байна. Явган хүний гарц, замын тэмдэг тэмдэглэгээг хангалттай байлгах нь хүүхдийг болзошгүй аюулаас сэргийлэх хамгийн чухал алхамуудын нэг юм. “Танай ангийн сандал, ширээ суухад тохиромжтой юу?, хүртээмжтэй юу?” асуумжийн хүрээнд хамгийн өндөр буюу 9 онооны хариулт өгсөн байгаа нь эцэг эх асран хамгаалагч нар хүүхдийн сурах орчны сандал ширээний стандартын хувьд сэтгэл хангалуун байгаа нь харагдаж байна. Хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх нь дан ганц аймаг орон нутгийн засаг захиргааны хийх ажил биш бөгөөд эцэг эх, асран хамгаалагч нар ч идэвхтэй байж хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлэхэд гар бие оролцох шаардлагатай байгаа талаар эцэг эхчүүдтэй хийсэн фокус ярилцлагын үеэр дурьдагдсан юм.



№	Асуултууд	Үнэлгээ									
		1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Танай орон нутагт хүүхэд хөгжлийн танхим байдаг уу?										
2	Чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн парк байдаг уу?										
3	Танай хүүхдийн сургууль дээр чамд чөлөөт цагаа өнгөрөөх газар /биеийн тамирын заал, дугуйлан, секц гэх мэт/ байдаг уу?										
4	Хүүхдэд зориулсан үзвэр үйлчилгээ хангалттай байдаг уу?										
5	Хүүхдэд зориулсан соёл,урлаг,спортын арга хэмжээ зохион байгуулж, хүүхдүүдийг идэвхтэй оролцуулдаг уу?										
6	Танай хүүхдийн хичээл хуваарийн дагуу бүрэн явагддаг уу?										
7	Хүүхдийн өөрийн удирдлагын болон оролцооны байгууллагуудын талаар мэдэх үү?										
8	Танай орон нутагт хүүхэд хамгааллын хамтарсан баг байдаг уу?										
9	Сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа гадуурхалт, дээрэлхэх, доромжлох асуудлын талаар сургуулийн багш, нийгмийн ажилтан, сургуулийн захирал арга хэмжээ авдаг уу?										
10	Орон нутгийн байгууллагуудаас өнчин, асран хамгаалагчгүй, нэн ядуу өрхийн хүүхэд, хурдан морь унадаг, хөдөлмөр эрхэлдэг гэх мэт хүүхдүүдэд анхаарал хандуулдаг уу?										
11	Орон нутгийн байгууллагуудаас гэмт хэрэгт холбогдсон, халдлагад өртсөн, эсвэл гэр бүлийн хүчирхийллийн гэрч болсон гэх мэт хүүхдүүдэд зөвлөгөө тусламж үзүүлдэг үү?										





Хүүхдийн хөгжил, хамгаалал, боловсролын чиглэлээр тусгайлсан дэд хөтөлбөрүүдийг батлан хэрэгжилтийг хангах зорилгоор орон нутгаас санхүүжилт төсвийг шат дараатайгаар нэмэгдүүлэх зарчмыг баримталж ажиллаж байгаа нь Хөгжил хамгаалал зорилтыг хангахад ач холбогдол өгсөн байна.

Орон нутгаас хүүхдийн асуудлаар санхүүгийн асуудлыг жил бүр шийдвэрлэж байгаа нь хүүхдийн оюун ухаан, хөгжилд онцгой хувь нэмэр оруулж байгаа нь Хүүхдэд ээлтэй орон нутаг болох шалгуур үзүүлэлтэнд нөлөөлж байна.

Хүүхдийн анхдагч орчин бол гэр бүл өрх гэр бүлд хүрэх нийгмийн үйлчилгээ оновчтой, хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй байвал улс орны эд эс болсон гэр бүл, гэр бүлийн хамгийн үнэт эрдэнэ болох хүүхэд бүхэн аз жаргалтай байна. Өрх гэр бүлийн жилийн ажлын хүрээнд Гэр бүлийн үнэ цэнэ, бат бэх байдал, гэр бүлийн боловсрол, ялангуяа залуу гэр бүлүүдэд чиглэсэн олон талт үйл ажиллагаануудыг зохион байгуулж байгаа нь Хүүхдэд ээлтэй орон нутгийн нэг шалгуур болох хүүхдэд ээлтэй өрх гэр бүлийг бэхжүүлэхэд түлхэц болж байна.

Ш. ҮНЭЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТЫН ДҮН.

Хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээг хийх явцад хүүхэд өсвөр үе, насанд хүрэгчид, холбогдох албан тушаалтнуудад үнэлгээний анхны болон II шатны үнэлгээний ажлын зорилго, зорилт, үйл явцын талаар тайлбар хийж мэдээлэл өгч ажиллаж явсан. Үнэлгээний санал асуулгад оролцож байгаа оролцогчдоод асуумжуудын талаар тайлбарлан, ойлгомжгүй асуумжуудад тайлбар өгөх зэргээр санал асуулгыг үр дүнтэй, ач холбогдолтой байхад анхаарч ажилласан. Тиймээс санал асуулгад оролцогчдоос хүчингүй буюу буруу тэмдэглэсэн хуудас харьцангуй бага байгаа нь санал асуулгад идэвхтэй оролцсон байна гэж үзэж байна.

ХҮҮХДИЙН САНАЛ АСУУЛГЫН ХАРЬЦУУЛАЛТ


Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв.

Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв бүлгийн 13 асуумжаас 1-8 хувиар ахисан үзүүлэлттэй 5 асуумж байгаа юм. Хамгийн өндөр буюу 8 хувиар ахисан асуумж нь:




- Хүүхдийн төлөө байгууллага болон сум хорооны Нийгмийн ажилтнууд хүүхдүүдтэй ярилцаж мэдээлэл солилцдог уу? Гэсэн асуумж байгаа нь хүүхдүүдтэй хамгийн ойрхон ажилладаг нийгмийн ажилтнууд өөрсдийн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа ч анхны үнэлгээнээс ахисан байгаа нь сайшаалтай байна.
- Орон нутгийн төрийн байгууллагууд хүүхэд эцэг эхийн санал, хүсэлтийг хүлээн авч, хариу өгдөг хайрцаг, дэвтэр ажиллуулдаг уу?, арга хэмжээ зохион байгуулдаг уу? Гэсэн асуумж нь 6 хувиар ахисан байна. Санал асуулгад оролцсон хүүхдүүд “Хүүхдээ сонсоё” арга хэмжээг сар бүр зохион байгуулдаг болсон талаар ярьж байгаа ч зарим тохиолдолд хувиараараа явагдахгүй, тасалдах үе байдаг гэсэн юм.
Харин Хүүхдэд ээлтэй засаглал төсөв бүлгийн асуумжаас 1 асуумжийн үнэлгээ 1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

- Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах шийдвэр гаргахдаа төр захиргааны байгууллага болон ТББ-аас хүүхэд эцэг эхчүүдийн дунд санал асуулга явуулдаг уу? гэдэг асуумж юм. Хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэр баримт бичиг бодлого хөтөлбөр гаргахдаа хүүхдийн өөрийн оролцоог хангаж тэдний дуу хоолойг сонсох нь маш чухал юм. Учир нь хүүхдүүд өөрсдөө асуудлаа тодорхойлж гарц шийдлээ олсоноор тухайн баримт бичиг хэрэгжих нөхцөл боломж илүү байх юм.



Хүүхдэд ээлтэй орчин

Хүүхдэд ээлтэй орчин бүлгийн үнэлгээнд анхны хийсэн үнэлгээнээс өссөн 4 асуумж байна. Хамгийн өндөр буюу 16




хувиар өссөн “Танай өрх гэр, сургууль, цэцэрлэгийн ойролцоо ногоон байгууламж байдаг уу? асуумж байна мөн 8 хувиар өссөн үнэлгээтэй “Танай ангийн сандал ширээ суухад тохиромжтой юу?, хүртээмжтэй юу?” гэсэн асуумж байсан бол “Танай гэрийн гадаа гудамж талбайн хаягжилт сайн байдаг уу? гэсэн асуумж 5 хувиар, “Танай орон нутагт явган хүний гарц, замын тэмдэг тэмдэглэгээ хангалттай байдаг уу? асуумж 3 хувиар өссөн байна.

Хүүхдийн амжилттай суралцах нэг хэсэг хүүхдийн сургалтын орчин буюу тэдний байнга суудаг сургалтын ширээ сандал юм. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 6782:2019 Монгол Улсын стандарт 2019 онд батлагдсан. Энэ стандартад: Анги танхимд тавих шаардлага. Сургуулийн хүүхдийн ширээ, сандал нь хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон, эрүүл ахуйн болон MNS 6582 стандартын шаардлагыг ханган гэж заасан. Хэдийгээр хүүхдүүдийн ширээ сандлыг стандартын шаардлагаар үнэлээгүй ч суухад



тохиромжтой, хүртээмжтэй байх талаар асуусан учир хүүхдүүд сайн хариултыг өгснөөр анхны үнэлгээнээс өссөн байна.

Хүүхдүүд өөрсдийн оршин суугаа газрын хаягжилт үнэн зөв, тодорхой тод байх нь ээлтэй орчны эрсдэл дагуулахгүй байх нэг боломж нөхцөл төдийгүй хүүхэдтэй ажилладаг сум, сургуулийн болон бусад Нийгмийн ажилтан, ялангуяа Хамтарсан багийн гишүүд, хүүхдийн төлөө ажилладаг ажилтнуудад ээлтэй орчин болох юм. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавигдах ерөнхий шардлага MNS 5283:2020 стандарт 2020 оны 10 дугаар сард батлагдсан байдаг. Стандартыг үндэслэн МУ-ын Засгийн газрын 2019 оны 325 тоот тогтоолоор “Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам” батлагдсан байна. Стандарт, журмаар гудамж зам талбайд байршуулах хаягийн тэмдгийн төрлийг 3 ангилж, гудамжны хаягийн тэмдэг нэг ангилалд нь багтсан байдаг. Хаяг, тэмдэг, тэмдэглэгээ нь хүний нүдэнд харагдахуйц, тод өнгөтэй, крилл үсгээр гэх мэт стандартуудыг тусгасан байгаа нь иргэд болон хүүхэд, хэн бүхэнд ил тод, ойлгомжтой байх шаардлагатай байна. Орон нутгийн хэмжээнд явган хүний гарц, замын тэмдэг, тэмдэглэгээ сайн байх нь хүүхдийн эсэн мэнд, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгаа гэж үзэж болно. Ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа хүүхдүүдийн хувьд сургуулийн орчны аюулгүй байдалд тавих шаардлагад: Сургуулийн ойролцоо байдаг авто зам нь хурд сааруулагчтай, аюулгүйн тэмдэг тэмдэглэгээтэй, MNS 6444 : 2014 стандартыг хангасан байна.






Хүүхдэд ээлтэй үйлчилгээ

Хүүхдэд ээлтэй үйлчилгээ бүлэгт 8 асуумжаар асуулга авсанаас 4 асуумжинд өмнөх үнэлгээнээс 3-12 хувиар ахисан үнэлгээ хүүхдүүд өгсөн байна. Хүүхдэд ээлтэй үйлчилгээнд 12 хувиар ахисан үнэлгээтэй асуумж “Танай сургуулийн цахилгаан, дулаан сайн байдаг уу?”



Шигтгээ: Манай сургуульд 3 охин байсан. Хүүхдүүд тэднийг атаман гэж айдаг байсан. Манай сургуульд “Банхар” ирэхэд тэр 3-г бид нар “Банхар”-тай уулзуулсан. Түүнээс хойш зүгээр болоод, одоо бид нартай хамт байж, найзалдаг болсон.(Инээв) 14 настай. С

гэсэн асуумж бол, “Сургууль цэцэрлэгт хүүхдэд зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан үдийн цай хоол өгдөг үү” гэсэн асуумж 8 хувиар ахисан үнэлгээтэй байна. “Сургууль цэцэрлэгийн бие засах газар тогтмол нээлттэй, цэвэрхэн байдаг уу?” гэсэн асуумж 1%-иар буурсан үзүүлэлттэй байна.



Хүүхдэд ээлтэй хөгжил хамгаалал



Хүүхдэд ээлтэй хөгжил хамгаалал бүлгийн хүрээнд 10 асуумжаар асуулга авч, өмнөх үнэлгээний асуумжтай харьцуулахад 6 асуумж 3-13 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Өндөр хувь буюу 13 хувь ахисан үзүүлэлттэй асуумж “Та нарын хичээл хуваарийн дагуу бүрэн явагддаг уу?”, “Чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн парк байдаг уу?” асуумж 12 хувиар, “Танай орон нутагт Хүүхэд хамгааллын хамтарсан баг байдаг уу? Тогтмол үйл ажиллагаа явуулдаг уу?” гэсэн асуумж 10 хувиар ахисан байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаа нь тогтмол хуваарийн дагуу тасралтгүй явагдаж байгаа нь хүүхдийн хөгжлийн давуу чанарт эерэгээр нөлөөлж байдаг. Хүүхэд өсвөр үеийнхний аж амьдралд байдаг давуу тал, дэмжлэгүүдийг Хөгжлийн давуу чанарууд гэж нэрлэх ба энэ нь хүүхдийн хөгжих, амжилттай суралцах, эрүүл байх, нийгмийн үйл ажиллагаанд утга төгөлдөр оролцох, өсвөр үеийнхэнд ухаалаг хариуцлагатай сонголт хийхэд нь тусламж үзүүлдэг. Өсвөр үеийнхэн хөгжлийн давуу чанаруудтай байснаар өөрийн




амьдралын эерэг сонголтыг хийж хүүхэд ба өсвөр наснаас насанд хүрэгч рүү амжилттай шилжихэд нөлөөлж, нөхцөл бүрдэж байгаа юм. Өмнөговь аймгийн хувьд бусад аймгуудаас анх удаа хүүхдийн парк буюу динозаворын хотхон байгуулсан нь аймгийн хүүхэд, залуучууд, иргэдэд төдийгүй бусад аймгуудад ч сонирхол татсан туршлага болохуйц ажил болсон юм. Тийм ч учраас хүүхэд, өсвөр үе залуучууд асуумжид өндөр үнэлгээг өгсөн байна. “Хамтарсан баг гэж” Монгол улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.5-д: Гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг хэлнэ гэж заасан. Хамтарсан баг нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хэрвээ хүчирхийлэл дарамтад өртсөн бол илрүүлэх, шуурхай таслан зогсоох, хүчирхийлэлд өртсөн хүүхэд гэр бүлд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй баг, хороо, сумын түвшинд ажилладаг нэгж юм.

Хамтарсан багийн талаар хүүхдүүд мэдэж, үнэлгээ өгч байгаа нь энэ талын мэдлэг, мэдээлэл, сурталчилгаа сайн байна гэж дүгнэж болох юм. Сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа гадуурхалт, дээрэлхэл, доромжлох асуудлын талаар сургуулийн багш, НАжилтан, захирал арга хэмжээ авдаг уу? Гэсэн асуумж 0,9 хувиар өмнөх үнэлгээнээс өссөн байна. Сүүлийн үед сургуулийн өсвөр насны хүүхдүүдийн дунд түгээмэл тохиолддог тулгамдсан асуудлын нэг бол үе тэнгийхний дээрэлхэлийн асуудал юм. Өмнөговь аймгийн хувьд энэ асуудалд хүүхдүүд эерэг хариулт өгсөн нь аймгийн ГБХЗХГазраас зохион байгуулж хэрэгжүүлсэн “Банхар” төслийн үйл ажиллагааг бүх сумдын сургуулиуддаа хэрэгжүүлж, үе тэнгийн, өсвөрийн сургагч хүүхдүүд бэлтгэн, студи байгуулан ажилласан юм. Энэ ажлын үр дүнд хүүхэд өсвөр үеийнхэн, үе тэнгийн дээрэлхэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байгаа нь фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын үед ярьсан юм.





НАСАНД



ХҮРЭГЧИДИЙН САНАЛ АСУУЛГЫН ХАРЬЦУУЛАЛТ.


Хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээний ажлын хүрээнд насанд хүрэгчидээс 4 бүлэг асуумжаар асуулга авч, анхны үнэлгээний үзүүлэлттэй харьцуулж, харьцуулалтын үнэлгээг танилцуулж байна.

Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв.

Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв асуумжийн дүнгээс харахад 4 асуумж 0,1- 0,5 хувиар ахисан үзүүлэлттэй байна.



“Хүүхдийн төлөө байгууллага болон сум хорооны нийгмийн ажилтнууд хүүхдүүдтэй ярилцаж мэдээлэл солилцдог уу? гэсэн асуумж 0,5 хувь, “Орон нутгийн албан хаагчид хүүхдийн эрхийн талаар мэдлэг мэдээлэлтэй байдаг уу?” асуумж 0,3 хувь, “Танай орон нутагт хүүхдэд зориулсан тусгай бодлого хөтөлбөрүүд байдаг уу?” асуумж 1 хувь, “Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн талаар мэдэх үү?” асуумж 0,1 хувиар ахисан байна. Хүүхэдтэй ажилладаг ажилтнуудын талаар хүүхдүүдээс гадна насанд хүрэгчид ч үйл ажиллагааг нь мэдэж байгаа учраас үнэлгээг хангалттай өгсөн нь өмнөх үзүүлэлтээс ахисан байна. Сум хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн байгууллагын ажилтнууд нь зөвхөн хүүхэдтэй ажиллаад зогсохгүй тэдний гэр бүлд түшиглэн нийгмийн ажил үйлчилгээг үзүүлж байдаг учраас иргэд энэ талын ойлголттой байна гэдэг нь харагдаж байна. Хүүхдийн эрхийн талаарх мэдлэг мэдээлэл түгээх нөлөөллийн ажлыг тэмдэглэлт өдөр, сарын аян, хэлэлцүүлэг, ярилцлага, уралдаан тэмцээн зэрэг төрөл бүрийн арга зүйгээр хүүхдийн байгууллагын болон нийгмийн ажилтнууд нь өөрсдийн чиг үүргийн дагуу тасралтгүй зохион байгуулан ажилласанаар гэр бүл хүүхдэд хүрч ажиллаж байгаа юм. Өмнөговь аймгийн хувьд иргэд, хүүхдэд зориулсан тусгай хөтөлбөрүүдийг боловсруулан ажилладаг нь орон нутгийн бодлогын баримт бичиг, зарим сумдын шийдвэр гаргах түвшний удирдлагуудтай уулзаж ярилцахад харагдаж байсан. Энэ талаар насанд хүрэгчид маань ойлголт сайтай байгаа бол харин хүүхдүүд ойлголт багатай байна. Аймгийн Засаг даргаар ахлуулсан ХТЗөвлөлийн талаар мэдлэг мэдээлэлтэй байгаа нь ажлын албанаас болон Зөвлөлийн бүрэлдэхүүнд байгаа салбар бүрийн зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэр, мэдээ мэдээлэл иргэд, хүүхдэд хүрч байгаа нь сайшаалтай байна. Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв бүлгийн асуумжид буурсан үнэлгээтэй асуумж байхгүй байна.



Хүүхдэд ээлтэй орчин


Насанд хүрэгчдээс авсан “Хүүхдэд ээлтэй орчин” бүлгийн үнэлгээнд 2 асуумж ахисан, 1 асуумж буурсан үнэлгээтэй байна. “Эмнэлэгт хүүхдэд зориулсан тусгай үзлэгийн өрөө байдаг уу?” гэсэн асуумж 0,2 хувиар, “Танай өрх гэр, сургууль, цэцэрлэгийн ойролцоо ногоон байгууламж байдаг уу?” асуумж 3 хувиар ахисан бол, буурсан үнэлгээтэй асуумж “Хүүхдүүд гадаа гудамжинд аюулгүй явах, тоглох тоглоом, гэрэлтүүлэг байдаг уу?”, буурсан үзүүлэлттэй байна. Өсвөр үеийн кабинетийн үлгэрчилсэн дүрэм Эрүүл мэндийн Сайдын 2017 оны 10 сарын 17-ны А/399 тоот тушаалаар батлагдсан. Энэ журмаар аймаг, дүүргийн Өсвөр үеийн кабинетын зорилт, тусламж үйлчлэгээний багц, үзлэг хийх, Өсвөр үеийн кабинетын их эмчийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт зэрэг бүх стандарт зарчмууд нь батлагдсан байдаг.



Хүүхэд өсвөр үеийнхэнд зориулсан кабинетийн талаар хүүхдүүд өөрсдөө мэдээлэл багатай, тэдний эцэг эх, асран хамгаалагчид мэдээлэл хэрэгтэй байна. Насанд хүрэгчид хүүхдүүд нь гадаа гудамжинд тоглоход хүүхдийн тоглоомын талбай багатай, мөн гэрэлтүүлэг хангалтгүй байгааг асуумжаар илэрхийлсэн байна. Хүүхдүүд байнга аймгийн төвд байгаа нэгдсэн тоглоомын талбай, парк зэрэг чөлөөт цагаа өнгөрөөх газарт очоод байхгүй, харин өөрийн гэрийн, оршин суугаа газрын ойролцоо тоглож наадах хүсэл эрмэлзэлтэй байдаг боловч энэ талд шаардлага хангахуйц тоглоомын талбай байдаггүй байна. Нийтийн эзэмшлийн газарт байрлах тоглоомын талбайн стандарт нь 2019 оны 02 дугаар сард батлагдсан байдаг.

Хүүхдийн аюулгүй байдлыг хангахад анхаарах нэг асуудал бол гудамжны гэрэлтүүлгийн асуудал юм. Энэ асуудалд эцэг эх, асран хамгаалагчид бага үнэлгээ өгсөн нь өмнөх үнэлгээнээс буурсан үзүүлэлттэй байна.


МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” хөдөлгөөн өрнөж, жилд 2 удаа бүх нийтээр мод тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүлж байгаа ч түүнийг арчилж хамгаалах, услах, ургуулах тал дээр төдийлөн ахиц гарахгүй байгаа юм. Мөн байгууллага хамт олноороо нэгдсэн журмаар аян хөдөлгөөнд оролцоод, иргэд харин өөрсдөө хашаандаа болон оршин суугаа газартаа ногоон байгууламжаа нэмэгдүүлэх талд санаачилга багатай ажиллаж байгаа нь улсын хэмжээнд харагдаж байдаг.



Хүүхдэд ээлтэй үйлчилгээ

Хүүхдэд ээлтэй үйлчилгээ бүлгийн үнэлгээнд насанд хүрэгчид 3 асуумжид ахисан үнэлгээтэй үнэлсэн байна. “Хүүхдэд зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан үдийн цай, хоол өгдөг үү?” асуумж 0,5 хувиар, “Хүүхдийн вакциныг товлосон хугацаанд хийдэг үү?” асуумж 0,3 хувиар, “Хүүхдийн шүдний өвчлөлийг оношлох, эмчлэх, зөвлөгөө өгөх газар байдаг уу?” асуумж 0,3 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Хүүхдэд ээлтэй үйлчилгээнд буурсан үзүүлэлт гараагүй байна.





Хүүхдэд ээлтэй хөгжил, хамгаалал


Гэр бүлд суурилсан хөгжил хамгааллын бодлогыг урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээгээр дамжуулан нийт хүүхэд, гэр бүл, зорилтот бүлгийн хүмүүст хүргэж, хүүхэд хамгааллын үйлчилгээний механизмыг орон нутагт бий болгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлчилгээ, нөлөөллийг тогтмолжуулах, хүүхдийн хөгжил, оролцоог хангахорчин бүрдүүлэхэд орон нутгийн зүгээс түлхүү анхаарч ажиллах нь төрийн үүрэг юм. Хүүхдэд ээлтэй хөгжил, хамгаалал бүлэгт 3 асуумж ахисан үнэлгээтэй байна.

“Таны хүүхэд чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн парк байдаг уу?” асуумж 0,5 хувиар, “Танай хүүхдэд зориулсан соёл урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулж, тэднийг идэвхтэй оролцуулдаг уу?” асуумж 0,4 хувиар, “Танай орон нутагт хүүхэд хамгааллын хамтарсан баг байдаг уу?, энэ баг тогтмол үйл ажиллагаа явуулдаг уу?” гэсэн асуумж 0,2 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

Хүүхэд, өсвөр үе, залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх гол объект Хүүхдийн паркийн талаар эцэг эхчүүд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн байна. Хүүхдүүд ч мөн адил энэ асуумжид сайн үнэлгээ өгсөн юм.

Орон нутгийн зүгээс хүүхдэд зориулсан төрөл бүрийн арга хэмжээг урлаг, спорт гээд олон хэлбэрээр зохион байгуулан ажилладаг байна. Хүүхдийн хөгжил, оролцоог хангасан хүүхдийн өөрийн удирдлагын болон оролцооны байгууллагууд байгуулагдан, хүүхэд бүр өөрийн сонирхол, сайн дурын үндсэн дээр найз нөхдийн хамт эвлэлдэн нэгдэж байдаг. Өмнөговь аймгийн хэмжээнд ХӨУдирдлагын болон оролцооны 72 байгууллага байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 39 байгууллагын үйл ажиллагаа тогтмолжин 4300 гаруй хүүхэд, өсвөр үе хамрагдан үзэл бодлоо илэрхийлэн ажиллаж байгаа юм. Хүүхэд бүрийг хөгжих, хамгаалуулах адил тэгш боломжоор хангах нь “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн эрхэм зорилго юм. Үүнийг үр дүнтэй, тасралтгүй, тогтвортой байдлыг хангахад орон нутгийн хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоо, механизм чухал нөлөөтэй. Хүүхэд хамгааллын үйлчилгээний гол нэгж Хамтарсан баг юм. Хүүхэд хамгааллын Хамтарсан багийн талаар хүүхдүүд төдийгүй, иргэд ч мэдээлэлтэй, үйл ажиллагааны талаар хариулж байгаа нь сайшаалтай байна. Хүүхэд хамгааллын Хамтарсан багийн талаар мэдээлэлтэй, үйл ажиллагаа нь сайн байснаар аливаа бүх төрлийн хүчирхийлэл, ялангуяа хүүхдийн эсрэг хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж, хамгаалж чадах сайн талтай. Асуумжуудаас буурсан үзүүлэлттэй асуумж байхгүй байна.





Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн зөвлөмжийн хэрэгжилт

Хүүхдэд ээлтэй орон нутаг анхны үнэлгээний зөвлөмжийг НҮБ-ын Хүүхдийн сангийн “Хүүхдэд ээлтэй хот, орон нутаг” гарын авлагын хүрээнд боловсруулагдсан Хүүхдэд ээлтэй орон нутгийг хөгжүүлэхэд анхаарах 4 зорилго, үр дүнг хангах хэрэгжүүлэх чиглэлээр өгсөн юм. Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхдээ 4 зорилгын хүрээнд тусгасан үйл ажиллагаануудыг агуулгын хүрээнд багцалж авч үзсэн юм.

Нэг.Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв:

Хүүхдэд ээлтэй орон нутаг 2020 оны үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор орон нутгийн зүгээс холбогдох баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж ирсэн байна. Үүнд:

1. Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “**Нутгийн хишиг**” хөтөлбөрийн 5 зорилт 195 үйл ажиллагаанаас “Хүүхдэд ээлтэй орон нутаг” үнэлгээний асуумж зөвлөмжтэй холбоотой 36 үйл ажиллагаа тусгагджээ.

- Зорилт 1: - 2 асуудал
- Зорилт 2: -17 асуудал
- Зорилт 3: - 5 асуудал
- Зорилт 4: - 10 асуудал
- Зорилт 5: -2 асуудал нийт 36 асуудлыг тусган хэрэгжүүлж байна.

“Нутгийн хишиг” хөтөлбөр нь 2023 оны байдлаар 95 хувьтай хэрэгжсэн бол, хөтөлбөрт туссан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” үнэлгээний зөвлөмжийн асуудлууд нь 100 хувь хэрэгжсэн байна.

Хүүхдэд ээлтэй аймгийг хөгжүүлэх замаар аймгийн тогтвортой хөгжлийг хангах үзэл баримтлалд нийгмийг чиглүүлэх, дэмжих ажлыг үндэсний бодлого хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэхэд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд өөрсдийн чиг үүргийн хүрээнд хүүхэд өсвөр үеийнхэнд ээлтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байгаагаас

- “Говийн ирээдүй хүүхэд”
- “Чадварлаг багш”
- “Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая”
- “Сурагч солилцоо”
- “Гэр бүл, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах” дэд хөтөлбөр
- “Хүүхдэд ээлтэй орон нутаг”



- “Хөгжлийн гүүр”
- “Агаарын бохирдолгүй Өмнөговь”
- “Цахим Өмнөговь”
- “Өсөлтийг өрх бүрт”
- “Эх хүүхдийн эрүүл мэнд”
- “Сүү, тараг”
- “Эрүүл элэг”
- “Харшлын эсрэг”

зэрэг хүүхдийн эрүүл мэнд тэдний эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл хоол хүнсээр хангагдах, өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгож, амьдрах ухаанд сургах чиглэл зорилготой хөтөлбөрүүд байна. Хөтөлбөр бүр өөрийн төсөвтэй, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон ажилладаг байна.

Аймгийн бодлого хөтөлбөрүүдээс гадна сумдууд өөрсдийн онцлогт чиглэсэн хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байгаагаас

- “Эрдэмтэй, ирээдүйтэй, эх оронч боловсрол” /Цогтцэций/
- “Эрүүл эерэг-Энх тунх иргэн” /Цогтцэций/
- “Ээлтэй эргэх холбоотой- Энэрэнгүй хөгжил”
- “Дэвшилтийг өрх бүрт” /Даланзадгад/
- “Дэвшилтэт хот- Оюунлаг залуус”

зэрэг хөтөлбөрүүд байна. Хүүхдэд ээлтэй орон нутаг анхны хөтөлбөр үнэлгээг хийх явцад орон нутгаас 5 төрлийн хөтөлбөрийг батлан 31,5 тэрбум төгрөгийг төсөвлөн хэрэгжүүлж байсан бол 2023 онд аймаг, орон нутгийн 18 хөтөлбөрт 100 гаруй тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр гаргасан ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн хувь 2020 онд 78 хувьтай байсан бол 2023 онд 93% болж өссөн байна. Хүүхдэд чиглэсэн тогтвортой үр дүн өөрчлөлтөд хүрэхийн тулд орон нутгийн засаг захиргаа өөрийн хяналтад байдаг бүхий л эрх зүйн баримт бичиг, бодлогодоо тусгаж хүүхдийн эрхийг дэмжиж хамгаалдаг.

Хүүхдийн асуудал дан ганц төрийн байгууллагын асуудал биш бүхий л салбарын үүрэг оролцоо болон салбар дундын зохицуулалт чухал байдаг.

Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хүрээнд “Хүүхдэд ээлтэй байгууллага” болох болзол журмыг баталж хэрэгжүүлснээр аймгийн Засаг даргын хүрээнд эрхлэх асуудлын хүрээний 63 агентлаг, төсөвт байгууллагууд “Хүүхэд хамгааллын бодлого”-той болж 127 байгууллагын эцэг эхийн зөвлөл тогтмолжин 2020-2023 онд 13 байгууллага хүүхдэд ээлтэй байгууллагаар шалгарсан байна.

Хоёр. Хүүхдэд ээлтэй орчин

Хүүхдийн амьдарч буй орчин аюулгүй, тэдэнд ээлтэй байх нь Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн чухал үзүүлэлтийн нэг юм. Хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхийн тулд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд олон ажлуудыг төлөвлөн хийсэн байна. Хүүхдийн орчны асуудалд хүүхэд олноор байдаг сургууль, цэцэрлэг, бусад үйлчилгээний газруудын ойр орчимд аюулгүй зоныг байгуулж, авто замын хөдөлгөөний төлөвлөлт, явган хүний зам гудамжны тэмдэг тэмдэглэгээ, ойр орчны гэрэлтүүлэг оршин суудаг газрын хаягжилт зэрэг нь хүүхдэд ээлтэй байх асуудал юм. Хүүхдийн тоглоомын талбайд тавигдах



ерөнхий шаардлагын дагуу Даланзадгад сумын 33 тоглоомын талбайд 7 хоног бүр үзлэг хийж нийт 12 зөрчлийг илрүүлэн, засаж сайжруулсан байна.

Боловсролын хяналтын чиглэлээр сургуулийн өмнөх байгууллага-31, ерөнхий боловсролын сургууль- 22, мэргэжлийн боловсролын байгууллага-3, дээд сургууль-1, дотуур байр-15, түр сургалтын байгууллага-5 нийт 80 байгууллагын бүртгэл судалгааг хийж, эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр 57 байгууллагыг үнэлснээс

- Их эрсдэлтэй 7
- Дунд эрсдэлтэй 42
- Бага эрсдэлтэй 8 байгууллага байсныг эрсдэлийг бууруулж засаж ажиллах зөвлөмж өгч ажилласан байна.

Мөн 22 сургуулийн 17 дотуур байранд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлын хэсэг гарч үнэлгээ хийн үнэлгээний дүгнэлтийн хүрээнд хариу арга хэмжээг авч ажилласан байна. Ногоон байггламжаа нэмэгдүүлэх ажлын хүрээнд 8 төрлийн модыг тарьж 241 байгууллага аж ахуй нэгжийн 2600 гаруй хүүхэд, залуучууд иргэд оролцсон байна. Явган хүний зам гудамжинд тэмдэг тэмдэглэгээ тавих орчны гэрэлтүүлгийг сайжруулах ажлын хүрээнд Цогтцэций сум орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021-2023 онд 735 гэрэл шинээр тавьж, 60 гэрлийг сэргээн засварлаж, 40 ширхэг замын тэмдэг тэмдэглэгээг шинээр хийсэн бол Ханбогд сум 399,024,657 төгрөгийг энэ ажилд зарцуулж, 288 гэрэлтүүлгийг шинээр хийсэн, Цогт-Овоо сум гэр хорооллуудыг бүрэн гэрэлтэй болгосон, Гурван тэс 188 замын гэрэлтүүлэгтэй болсон байна. Цогтцэций сумын онцгой байдлын хэлтэс, Тэгш дүүрэн тохижилт, ХХХбаг хамтран сумын ойр орчмын 2 км орчимд эрсдэлийн үнэлгээ хийж, тоглоомын талбайн эвдрэл, автомашины сэг, хуучин ашиглалтгүй болон дутуу баригдсан барилга байгууламжийн тоог гарган ажилласанаар 22 автомашины сэгийг ачиж зайлуулан, 286 нохой устгалын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн Ханбогд, Цогт-овоо, Гурван тэс сумууд “Хүүхдээ сонсох өдөр”-өөр хүүхдээс гаргасан саналын дагуу тэжээвэр муурыг хаягжуулан, золбин нохой устгах ажлыг 2-3 удаа зохион байгуулсан байна.

Үйлчилгээний байгууллагууд нь “Хүүхдэд ээлтэй орчин”-г бүрдүүлэхэд анхаарч 2023 онд 13 байгууллага шинээр хүүхдийн өрөөг тохижуулснаар нийт 41 байгууллага хүүхдийн өрөөтэй болсон байна.

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилготой “Сургуулийн цагдаа” ажлыг 2023 онд нийт 53 цэцэрлэг, сургууль зохион байгуулан ажилласан байна.

Гурав. Хүүхдэд ээлтэй үйлчилгээ

Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын өсвөр үеийн кабинетаар: 2023 онд 631 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэн, 22,9 хувийг эмчилгээнд хамруулж эрүүлжүүлэн, онош тодруулахаар 2,5 хувийг шилжүүлж, 4,2 хувьд нь сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад байгууллагад холбон зуучлах үйлчилгээ хүргэн ажилласан байна. Бүсийн оношлогоо эмчилгээний төвд ямар нэг зовиурийн улмаас тусламж хүсч 1145 хүүхэд хандаж үйлчлүүлсэн бол тэдний 31 хувь нь шүдний, 25,8 хувь нь гэмтлийн, 16,3 хувь арьс харшлын, 11 хувь сэтгэл зүйн зөвлөгөө, 10.6 хувь мэдрэлийн, 4.2 хувь нүдний, 0.9 хувь эмэгтэйчүүдийн, 0.3 хувь сэтгэцийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдаж эмчлүүлсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагын эмэгтэйчүүдийн кабинет, эх баригч нараар дамжуулан өсвөр үеийн охидод зөвлөгөө сургалт зохион байгуулах чиглэл, сургалтуудыг



тасралтгүй авч ажилласаны үр дүнд нийт төрөлтийн 4,3 хувь (57) охидын төрөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 0.7 хувь, өсвөр насны охидын үр хөндөлт- 6.3 хувь (25) байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 0,1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй, үйлчилгээг 1776 өсвөр үеийнхэнд үзүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 5 сумын /Гурвантэс, Манлай, Цогтцэций, Ханбогд, Ноён /эрүүл мэндийн төвд шүдний кабинетын тусламж үйлчилгээг хүргэж байна. Нийт хувийн хэвшлийн 8 шүдний эмнэлэг /ДЗ/, Говь дент төв, БОЭТ зэрэг нийт 15 кабинетаар амны хөндий, шүдний тусламж үйлчилгээ нийт 31509 хүнд үйлчилгээ үзүүлж, илэрсэн өвчлөлийн 62 хувьд нь эмчлэн эрүүлжүүлэх ломбо, түрхлэг зэрэг тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Орон нутагт анх удаагаа “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээнийг аймгийн төвийн 10 цэцэрлэгийн 5 настай 529 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Тус байгууллагатай хамтран ажиллах санал солилцох уулзалт арга хэмжээг 3 удаа зохион байгуулсан. Амны хөндий, шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх 2 төрлийн видео контент, 10 төрлийн мэдээллийн брошюр, гарын авлагыг 8000 гаруй хүнд хүргэж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд түгээж ажиллаа.

Аймгийн хэмжээнд “Сүү тараг” хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлгийн 7960 хүүхдийн судалгааг гаргаж нийт 191,040,00 төгрөгийг шийдвэрлэн 15 суманд шилжүүлэн хөтөлбөрийг хэрэгжүүлж, 6-12 сартай - 4195 хүүхэд, 2 хүртэлх насны ихэр- 351 хүүхэд, 12 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй -917 хүүхэд, Өсөлт хоцрогдолтой, жингийн алдагдалтай - 937 хүүхэд хамрагдаж, нийт 6750 (84,7%) хүүхэд бүрэн хамруулсан бөгөөд 13478.4 литр сүү, 16894.2 литр тараг, нийт 162,000,000 төгрөг зарцуулсан байна.

Өмнөговь аймаг 2023 оны 02-р сарын 15-ны өдрийн "Ерөнхий боловсролын сургуулийн 6-р ангид үдийн хоол өгөх тухай" Засаг даргын А/199 тоот захирамжаар нөөц хөрөнгөнөөс Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд улирал бүрийн гүйцэтгэлийг үндэслэн олгохоор 450.000.000 төгрөгийг төсөвлөсөн, 2023 онд ерөнхий боловсролын сургуулийн 6-р ангийн нийт 1555 хүүхдийн хоолонд 324,922,500 төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулаад байна.

2023 онд хүүхдэд зориулсан үйлчилгээг үзүүлэхэд 20 төрийн бус байгууллага 6 сайн дурын клуб нийт 26 хувийн байгууллагатай хамтран ажиллаж 32 арга хэмжээнд 4756 хүүхдийг хамруулж цахимаар 14747 хандалт авсан байна

Дөрөв. Хүүхдэд ээлтэй хөгжил, хамгаалал

2023 онд Ерөнхий боловсролын 22 сургуулийн хичээлээс гадуурх сургалтын ажлыг дэмжих, хүүхдийн оролцоо хэрэгцээнд суурилсан секц, дугуйлангийн үйл ажиллагааг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 08 дугаар сарын 17-ний өдрийн “ЕА/288 тушаалын хүрээнд 205 клуб, дугуйлангийн 226 төрөлд 7405 хүүхэд хамрагдсан байна.

Хүүхдийн хөгжлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг “Хүүхдийн ордон” 2022 оны 08 сараас эхлэн шинээр байгуулагдан, “Буянт хотхон” хүүхдийн зусланд 233 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

Хүүхдийн өөрийн удирдлагын 64 байгууллагат 3948 хүүхэд хамрагдан суралцаж байна.2023 онд 7 удаагийн уулзалт арга хэмжээгээр 54 байгууллагын 246 хүүхэдтэй уулзаж, тэдний үзэл бодол, санал санаачлагыг сонсон ажилласан байна. “Нэгдүгээрт хүүхэд” нөлөөллийн арга хэмжээг Даланзадгад, Ханбогд суманд сурагчдын дунд зохион байгуулж,



4 төрлийн үйл ажиллагаа, 6 төрлийн сургалт, 3 төрлийн тэмцээн уралдаанд 11656 хүн хамрагдсан байна.

- ХНХЯ, Дэлхийн зөн ОУБ, Монголын хүүхдийн зөвлөлөөс зохион байгуулсан үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг "НАЙЗ БАЙЯ" аяныг Өмнөговь аймагт зохион байгуулж 10688 хүүхэд өсвөр үе, залуучууд, иргэдэд хүрч ажилласан байна. Мөн "Чи ганцаараа биш" нөлөөллийн аяныг Даланзадгад сумын 6 Ерөнхий боловсролын сургуулиудын Хүүхэд хамгааллын багтай болон Политехникийн коллежийн хамт олонтой хамтран зохион байгуулсан. Тус аяны хүрээнд 3 төрлийн уралдааныг 7 сургууль дээр зохион байгуулж 969 хүүхэд хамрагдсан.

Аймгийн засаг даргын 2021.02.18-ны А/185 дугаар захирамжаар " Хүүхдээ сонсох өдрийг зохион байгуулах тухай" шийдвэрийн дагуу хэрэгжилтийг хангаж "Хүүхдээ сонсох өдөр"-ийг Даланзадгад сум 16 удаа зохион байгуулж, аймаг сумын удирдлагууд 842 хүүхдийг хүлээн авч уулзан, 165 санал хүсэлтийг сонсож, 108 санал хүсэлтийг шийдвэрлэсэн байна. ХТЗ-ийн тэргүүн нь "Хүүхдээ сонсох өдөр" арга хэмжээгээр дамжуулан хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэсэн 25 шийдвэрийг гаргасан байна.

"Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал" сургалтыг 1232 хүнд хүргэсэн, 4 төрлийн арга хэмжээгээр дамжуулан -18 сургалт, төвлөрсөн арга хэмжээ-2 удаа, бүлгийн хэлэлцүүлэг-4 удаа зохион байгуулж, 2 шторк, 3 төрлийн постер 3 төрлийн гарын авлага тараах материалыг бэлтгэн тараасан. Уг арга хэмжээнд нийт 9952 хүнийг хамруулснаар хүүхдэд тавих хараа хяналт сайжирсан.

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 15, гэмт хэргийн хохирогч 29, сэжигтэн 12, бэлгийн хүчирхийлэлд 20 хүүхэд өртсөн байна. Бэлгийн хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 64 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, 20 хүүхдийн өмгөөллийн зардлыг 100 хувь шийдвэрлэсэн. 15 хүүхдийг Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэнд үзүүлж, 63 удаагийн сэтгэл заслын үйлчилгээг Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран үзүүлсэн. Гэмт хэргийн хохирогч 29 хүүхдийг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээнд байрлуулан, 12 хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 6 хүүхдийг Хөдөлмөрийн дадал суулгаж мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулж, 18 хүүхдийг өсвөр үеийн кабинетад холбон зуучилж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн.

Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын сургалтад 1594 багш суралцсан байна. Зөвлөгөө өгөх 3 төвөөр дамжуулан 7185 хүнийг сургалтад хамруулж зөвлөгөө өгсөн байна.

Иргэд, олон нийт, хүүхэд залуучууд, уул уурхайн компанийн ажилчдад нийгэмд тулгамдаж буй гэр бүлийн хүчирхийлэл, хосуудын гэр бүлийн зөрчил, хүүхдийн эрхийн зөрчил, үл хайхрагдаж буй хүүхдүүд, үе тэнгийн дээрэлхэл, цахим гэмт хэрэг зэрэг 8 агуулгыг багтаасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Хөшгөө нээ" сургалт, мюзикл соён гэгээрүүлэх, хууль сурталчлах ажлыг зохион байгуулж, уг арга хэмжээгээр дамжуулан урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 2645 хүн хамрагдсан байна.

Аймгийн хэмжээнд 22 хамтарсан баг 256 гишүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Өмнөговь аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ-ын ХЭЗХ, ГБХЗХГ, "Галт шувуу" ТББ хамтран аймгийн 22 хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. Сургалтад 15 сумын 22 хамтарсан багийн 87 гишүүн хамрагдсан.



2023 оны байдлаар байдлаар 24 Хамтарсан багт 262 Хамтарсан багийн гишүүд ажиллаж, 253 кейсийг бүртгэж, 252 кейсийг шийдвэрлэж 99,6 хувьтай, ажиллаж байгаа 1 кейс байна.

-Кристина нобелийн хүүхдийн сангаас зохион байгуулсан “Баяртай төсөл”-ийн хүрээнд монголд анх удаа урлагын сэтгэл заслын тусламжтайгаар асрамж халамжийн төвүүд, хүүхэд хамгаалах байгууллагын сэтгэл зүйчдийг чадавхижуулах, “Урлагийн сэтгэл заслын арга зүй, техникээр чадавхижуулах нь” сургалтад хамрагдан 6-10 насны 1000 хүүхдэд хүрч ажилласан.

2023 онд хүүхдийн тусламжийн 108 утсанд 110 дуудлага мэдээлэл ирснээс 99 дуудлагыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж, 11 дуудлагад ажиллаж, кейс шийдвэрлэлтийн хувь 90,1 хувьтай байна.

Байгууллагын дэргэдэх 70532205 утсанд 98 дуудлага бүртгэгдсэнийг бүрэн шийдвэрлэж хаасан.

“ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ” ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн хүүхдэд ээлтэй байдлыг үнэлж буй шалгуур үзүүлэлтүүд нь өөр хоорондоо ялгаатай хэмжих нэгжээр илэрхийлэгддэг тул тэдгээрийг нэгдсэн нэг хэмжүүрт оруулахын тулд 1-10 хүртэлх онооны байдлаар дүгнэсэн болно.

- 1-4 хүртэлх үнэлгээ нь “Хүүхдэд ээлгүй орон нутаг”,
- 5-8 хүртэлх үнэлгээ “Хүүхдэд ээлтэй орон нутаг болох боломжтой”,
- 9-10 хүртэлх үнэлгээ нь “Хүүхдэд ээлтэй орон нутаг” гэсэн үнэлгээгээр тодорхойлогдож байгаа юм.

Хүүхэд эцэг эхчүүдээс авсан санал асуулга ярилцлагын үнэлгээний 1-4 хүртэлх үнэлгээ авч байгаа асуумжид орон нутгийн бүх байгууллагууд анхаарч тусгай төлөвлөгөө гарган ажилласнаар үнэлгээгээ сайжруулах боломжтой юм.

Энэхүү асуумжаар авах судалгааны аргачлал нь хүүхдүүд, эцэг эх, асран хамгаалагчид болон үйлчилгээ үзүүлэгчдийг хамруулан асуумж авах статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх чиглэлээр боловсруулагдсан тул үнэлгээний аргачлалаар объектив болон субъектив мэдээллийн аль алийг цуглуулах боломжийг олгож байгаа бөгөөд энэ хоёр төрлийн мэдээллийн эх сурвалж нь харилцан бие биеэ баталгаажуулах, нэмэлт мэдээллээр хангах ач холбогдолтой.

Хүүхдэд ээлтэй орон нутгийн шалгуур үзүүлэлтүүдийн нэгдсэн үнэлгээ

№	Асуумжын хариулт	Үнэлгээ /Хүүхэд/	Үнэлгээ /Эцэг эхчүүд/
1	Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв	8.2	7
2	Хүүхдэд ээлтэй орчин	8.2	5.5
3	Хүүхдэд ээлтэй үйлчилгээ	8.0	7.1
4	Хүүхдэд ээлтэй хөгжил, хамгаалал	8.8	6.9
Дундаж үнэлгээ		8.3	6.6
Ерөнхий дундаж үнэлгээ		7.45	
2020 оны үнэлгээ		6,36	

Хүүхдээс авсан судалгааны сайн болон дунд үнэлгээний дундаж нь 83%-г эзэлж байна. Үүнийг 1-10 хүртэлх онооны аргад шилжүүлэн 10 оноог 100% гэж үзвэл 83%-ийг 8,3



оноо гэж үнэлж байна. Судалгааг нэгтгэн судалгааны аргачлалаар тоон үнэлгээрүү шилжүүлэн үзэхэд ерөнхий дундаж үнэлгээ нь 7.45 оноо гарч байгаа нь хүүхдэд ээлтэй орон нутаг болох боломжтой гэсэн шаардлагыг хангаж байна. Энэ нь 2020 онд хийгдсэн үнэлгээтэй харьцуулахад 1,09 хувиар өссөн байгаа нь Өмнөговь аймаг “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд “Хүүхдэд ээлтэй байдал” – тодорхой хувиар хангасан үзүүлэлт гарч байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн хүүхдэд ээлтэй байдлыг сайжруулснаар гарах хамгийн гол үр нөлөө нь тухайн аймаг орон нутагт амьдарч буй хүүхэд бүрийн эрх хангагдаж, тэд хүүхэд насандаа бүрэн дүүрэн аз жаргалтай амьдарч, сурч хөгжих нөхцөл боломж бүрдсэн байх явдал юм. Тиймээс хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээний 4 бүлгийн хүрээнд хүүхэд, насанд хүрэгчдээс асуусан асуумжид бага оноо авсан үзүүлэлт, мөн ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагаар анхаарал татаж байсан асуултуудыг сайжруулах талаар цаашид анхаарч ажиллах нь “Хүүхдэд ээлтэй орон нутаг” болох үнэлгээний шалгуурт нийцэх юм.

• Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв.

- 1.Орон нутгийн засаг захиргаанаас хүүхдэд зориулсан бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө шийдвэрүүдийг батлан гаргахдаа хүүхдүүддээр өөрсдөөр нь хэлэлцүүлж байх, тэдний төлөөлөлтэй уулзаж санал бодлыг нь тусгах.
- 2.Хүүхдэд зориулан батлагдсан төсөв, хөрөнгө, хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл өгч танилцуулж байх, төсвийн хөрөнгөнөөс гадна өөр бусад эх үүсвэрээс хөрөнгө олох боломжийг судалж ажиллах.
- 3.Аймгийн Засаг даргаар ахлуулсан хүүхдийн эрхийг хангах талаархи салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий ХТЗөвлөлийн мэдээлэл, зөвлөлийн бүрэлдэхүүнд тэдний төлөөлөл сонгогдон ажилладаг талаар сурталчлан танилцуулах.
- 4.Аймгийн ИТХуралдаанаар хүүхдийн эрх ашигт нөлөөлөх асуудлыг хэлэлцэх үед олон нийтэд болон хүүхдүүдэд мэдээллийн хэрэгслээр нээлттэй дамжуулдаг болох.

• Хүүхдэд ээлтэй орчин.

- 1.Хүүхдийн аюулгүй орчны нэг болох явган хүний гарц, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах. Ялангуяа төв авто замын ойролцоо байршилтай сургууль, цэцэрлэгүүдийн өмнө хурд сааруулагч, “Анхаар хүүхэд” тэмдэг тэмдэглэгээг олноор байршуулах 8 сургууль цэцэрлэгийн автомашины зогсоолыг цэгцэлж тэмдэг тэмдэглэгээг сайжруулах /зөвхөн багш ажилчдын автомашин зогсож, өдөржин дүүрэн байгааг анхаарах/
2. Сургууль, цэцэрлэг, үйлчилгээний томоохон газруудын ариун цэврийн байгууламжийг хүрэлцээтэй хэмжээгээр, мөн ХБХүүхэд, бага насны хүүхэд зэрэг хүүхдийн нас болон хүйсний онцлогт тохирсон байлгах.
- 3.Хүүхдүүд гадаа гудамжинд аюулгүй явах нөхцөл боломжийг бүрдүүлэн гудамжны болон замын гэрэлтүүлгийн асуудлыг бүрэн шийдвэрлэх.
- 4.Хүн олноор цугладаг үйлчилгээний газрууд болон алслагдсан зайд байршилтай зарим гудамж хорооллуудад камержуулалтын асуудлыг шийдвэрлэж аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх.



5.Стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомын талбайголноор барьж байгуулах, хүүхдийн амьдарч байгаа орчинд нь ойртуулж барьж байгуулахад анхаарах.

• ***Хүүхдэд ээлтэй үйлчилгээ.***

1. Хүний амь нас, амьдралын чанарт хохирол учруулах, Хөгжлийн бэрхшээлд хүргэж болзошгүй, халдварт болон халдварт бус өвчнийг эрт үед нь илрүүлэх, ирээдүйд учирч болзошгүй хүндрэл, нас баралт сэргийлэх ач холбогдолтой эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийг хүүхдүүдийн дунд жил тутам хийж, эцэг эхчүүдэд нь нэг бүрчлэн зөвлөмж өгч хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудалд анхаарах.
2. Хүүхдүүдэд зонхилон тохиолддог шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлуудыг холбогдох байгууллагууд хамтран зохион байгуулах, ялангуяа хүүхдүүдэд бага наснаас нь эхэлж шүдээ хэрхэн угаах, шүдээ өвтгөхгүйн тулд идэж болох, болохгүй хүнсний зүйл зэрэг хүүхдүүдийн зайлшгүй мэдэж байх мэдлэг мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол явуулах, хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулахад онцгойлон анхаарах.
3. Тусгай хэрэгцээт буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургууль цэцэрлэгт тэгш хамрагдах бүх талын боломжийг бүрдүүлж ажиллах, олон нийт, хүүхдүүдийн ойлголт хандлагыг өөрчлөх, сургалт мэдээллийг тогтмол хийх.
4. Сургууль, цэцэрлэг, үйлчилгээний газруудад байгаа ариун цэврийн өрөө бие засах газруудыг байнга нээлттэй байлгаж, үйлчилгээний чанарыг сайжруулах, сургууль цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний хүртээмжийг нэмэгдүүлэх.

• ***Хүүхдэд ээлтэй хөгжил хамгаалал.***

1. Хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөл боломжийг бүрдүүлж, сургуулийн биеийн тамирын заал, дугуйлан секцийг хүүхэд бүрт хүртээмжтэй байлгах тал дээр анхаарч ажиллах, нэмэгдүүлэх
2. Сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа үе тэнгийн дээрэлхэл, гадуурхалтын асуудлыг таслан зогсоох чиглэлээр холбогдох газрууд хамтран үе шаттай ажлуудыг зохион байгуулах. Энэ талын мэдээллийг авахдаа хохирогч болон гэрч хүүхдийн аюулгүй байдлыг ханган, нууцлалыг ханган ажиллах, сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулах
3. Эрсдэлт нөхцөлд байгаа болон өнчин, асран хамгаалагчгүй, хурдан морь унадаг, хөдөлмөр эрхэлдэг зэрэг хүүхдүүдийн судалгаа мэдээллийг жил бүр шинэчлэн мэдээллийн сан үүсгэн, тэдэнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээг хүргэхэд анхаарч ажиллах.
4. Хүүхдүүдийн нас, сэтгэхүйд тохирсон үзвэр үйлчилгээг хүүхдүүдэд хүргэх, зорилтот өрхийн хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх

ДҮГНЭЛТ:

Хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээ нь хүүхдийн аж байдлыг сайжруулахын тулд хүүхдийн эрхийн асуудлыг цогцоор нь авч үзэж шийдвэрлэх зорилготой тул тухайн улсын Засгийн газар тогтвортой хөгжлийн зорилгуудыг хангахад шууд болон шууд бусаар дэмжлэг үзүүлнэ. Иймээс хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр болон 2030 он хүртэлх



хөтөлбөрийн уялдаа холбоо нь Тогтвортой хөгжлийн зорилгын зорилтыг хангах болон орон нутгийн хөгжлийн зорилтуудыг хангахад чиглэгддэг.

Хүүхдэд ээлтэй орон нутгийг хөгжүүлэх нь хүүхдийг үл ялгаварлах, эсэн мэнд амьдрах, хөгжих, оролцох үндсэн эрхүүдийг хангахад чиглэсэн хүүхдийн эрхэд суурилсан загвар бөгөөд төр хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд дараах үүргийг хүлээж, хариуцлага үүрэх ёстой гэдгийг онцолдог. Тухайлбал:

- **Хүндэтгэх**- Хүүхэд эрхээ эдлэхэд төр хөндлөнгөөс шууд ба шууд бусаар саад учруулах ёсгүй.
- **Хамгаалах**- Хүүхдийг эрхээ эдлэхэд саад хийхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ёстой
- **Дэмжих**- Хүүхдийн эрхийг бүрэн хангахад чиглэсэн хууль эрх зүй, засаг захиргааны, төсвийн шүүхийн, урамшууллын зэрэг арга хэмжээг авах ёстой
- **Хангах**- Хүүхдийн эрхийг бодит болгоход чиглэсэн тусламж, үйлчилгээг төр шууд үзүүлэх ёстой.

Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр нь салбар дундын хамтын ажиллагааг шаардсан санаачилга тул хэрэгжүүлэх шат бүрд орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн салбаруудын оролцоо, хамтын ажиллагаа бүхий түншлэлийг бий болгох нь чухал юм.

Аймаг орон нутгийн засаг захиргаа нь өөрийн хяналтад байдаг бүхий л эрх зүйн баримт бичиг, бодлогынхоо хүрээнд хүүхдийн эрхийг дэмжиж хамгаалах ёстой. Хүүхдийн эрхийн тухай ойлголттой болох нь мэдээлэл харилцааны ажлыг үр дүнтэй явуулахад чухал үүрэгтэй. Орон нутгийн шийдвэр гаргагчид, төрийн болон төрийн бус байгууллагууд, төрийн албан хаагчид, иргэний нийгмийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагчид, хүүхдүүд бүгд хүүхдийн эрхийн талаар ойлголттой, өдөр тутмын үйл ажиллагаандаа баримталдаг байх ёстой.

Хүүхдэд ээлтэй аймаг орон нутаг нь хүүхэд өсвөр үеийнхнийг үйл ажиллагаандаа татан оролцуулснаар, эрүүл аж төрөхүй, аюулгүй байдлыг нь хөхүүлэн дэмждэг бөгөөд “хүүхдэд ээлтэй олон нийт нь нийгмийн хариуцлагыг ухамсарлан, хүүхдийн бүх талын хөгжилд нийтээрээ оролцох ёстой” гэсэн хандлагыг дэмжиж ажилладаг. Хүүхдэд ээлтэй орон нутгийг хөгжүүлж, хүүхдийн байдлыг бодитоор өөрчлөхөд улс төрийн дэмжлэг, бодлогын шинэчлэл өөрчлөлтийг хийх хүчин чармайлт туйлын чухал юм.

Хүүхдэд ээлтэй аймаг, орон нутгийг хөгжүүлэх нь “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” санаачлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд хүүхдийн эрхийг бүх түвшинд хэрэгжүүлэх, улмаар “Тогтвортой хөгжлийн зорилго”-ын хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэхэд хувь нэмрээ оруулах юм.

Өмнөговь аймаг “Хүүхдэд ээлтэй орон нутаг” болоход дөхөмтэй үнэлэгдэж буй нь бусад аймгуудтай харьцуулахад хүүхдэд илүү их ээлтэй бодлого шийдвэр гаргаж, хүүхдийн хөгжил хамгаалалд зориулсан төсвийг жилээс жилд нэмэгдүүлж, хүүхдийн эрхийн мэдрэмжтэй ажиллаж байгаад ажлын хэсэг талархал илэрхийлье.

